СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ

# МОНГОЛ НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

## HISTORICAL AND CULTURAL IMMOVABLE MONUMENTS IN MONGOLIA

I ДЭВТЭР

ХЭНТИЙ АЙМАГ





# МОНГОЛ НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

I ДЭВТЭР

ХЭНТИЙ АЙМАГ

DDC
306′09′517′
Э-66

**Зохиогч:**
Г.ЭНХБАТ
Б.ДАВААЦЭРЭН

**Гэрэл зургийг:**
Б.ДАВААЦЭРЭН

**Гар зургийг:**
Г.СОЁЛ-ЭРДЭНЭ

**Дизайнер:**
Б.АЛТАНСҮХ

**Орчуулагч:**
Ц.ЦОЛМОН

Зохиогчийн эрх хамгаалагдсан. © 2010,
Соёлын өвийн төв, Улаанбаатар, Монгол улс

Copyrigth © 2010 by the Center of Cultural
Heritage, Ulaanbaatar, Mongolia

Энэхүү цомгийг Соёлын өвийн төвийн зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн
хувилан олшруулахыг хориглоно.

---

Монгол улс
Улаанбаатар хот - 211238
Сүхбаатар дүүрэг
Сүхбаатарын талбай 3
Соёлын төв өргөө Б хэсэг
Соёлын өвийн төв

Шуудангийн хайрцаг 223
Веб сайт: www.immovable.eheritage.mn
И-мэйл: cch_fund@monheritage.mn
Утас: 976-11-312735

---

ISBN 978-99929-61-32-5

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам

Соёлын өвийн төв

Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн

Хэнтий аймгийн ЗДТГазар

Монголын урлагийн зөвлөл



# ГАРЧИГ


Өмнөх үг 6

Удиртгал 7

Хэнтий аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тухай 20

Хэнтий аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршил 31

Батноров сум 32

Батширээт сум 36

Баян-Адрага сум 42

Баянмөнх сум 47

Баян-Овоо сум 52

Баянхутаг сум 58

Биндэр сум 64

Галшар сум 69

Дадал сум 71

Дархан сум 76

Дэлгэрхаан сум 81

Жаргалтхаан сум 88

Мөрөн сум 92

Норовлин сум

Өмнөдэлгэр сум 96

Хэрлэн сум 100

Цэнхэрмандал сум 100

Хэнтий аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

Товчилсон үгийн тайлал

Ашигласан ном бүтээлийн жагсаалт

# ӨМНӨХ ҮГ

БСШУЯ-ны харьяа Соёлын өвийн төв монгол нутагт орших буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг анхан шатны байдлаар бүртгэн баримтжуулах, тоолох, хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдалд судалгаа хийх ажлыг 2008-2015 онд гүйцэтгэхээр төлөвлөн 2008 оноос хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Бид энэхүү ажлын үр дүнг олон нийтэд зорилгоор бүртгэл судалгааны ажлын үеэр цугларсан мэдээллийг Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээллээр баяжуулан гэрэл зургийн цуврал цомгийг хэвлүүлж олон нийтэд түгээж эхлээд байна. Үүний эхний дэвтэр нь 2008 онд хэвлэгдсэн Хэнтий аймгийн түүх, соёлын дурсгалын гэрэл зургийг багтаасан цомог юм. Энэхүү цомогт Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт болон судалгааны байдлыг товчлон оруулж, ард нь сумдын нутаг дахь үл хөдлөх дурсгалын жагсаалтыг жагсааж, гэрэл зурагт нэрийг хадаж өгсөн юм.

Бидний хэвлүүлсэн эхний цомог болох Хэнтий, Сүхбаатар аймгийн цомгийг гаргасны дараа судлаачид болон ард иргэдээс тайлбар, мэдээллийг аль болох нэмэх талаар санал их ирж байв. Бид ирсэн санал хүсэлтийг нэгтгэн дараагийн цуврал болох Дорнод, Дорноговь аймгуудын цомогт тусгаж хэвлүүлсэн бөгөөд цаашид эдгээр цомгийн хэв загварыг баримтлан дараагийн цомгоо хэвлүүлэх юм. Бид энэхүү нэмж засварласан цомогтоо Хэнтий аймгийн нутагт орших түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой дурсгалт газрыг сонгон авч, байршлыг нь газрын зурагт байрлуулан товч тайлбарын хамт оруулж, сум тус бүрийн нутагт орших дурсгалын жагсаалтыг ард нь хавсаргалаа. Мөн дурсгалуудын хадгалалт хамгаалалтын талаар авч хэрэгжүүлж байсан төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааг хураангуйлан оруулсны зэрэгцээ судалгааны ажлын тоймыг нэмсэн болно.

Энэхүү цомог нь эрдэм шинжилгээ, судалгааны зориулалттай бус зөвхөн түүх, соёлын дурсгалыг ард иргэдэд сурталчилан таниулах зорилготой гаргаж байгаа учир мэдээллийг товчлон оруулсан болно. Уншигч та Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгалын талаар илүү их мэдээлэл авах, эсвэл энэхүү цомогтой холбоотой санал хүсэлт, шүүмж байвал манай байгууллагын хаягаар хандахыг хүсье.

Эртний түүх, соёлын өвөө эрхэмлэн дээдлэгч ард иргэд та бүхэн энэхүү гэрэл зургийн цомгоор дамжуулан Монгол нутгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудтай танилцаж, тэдгээрийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх үйлсэд өөрсдийн хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Зохиогчид

# FOREWORD

The Center of Cultural Heritage under the Ministry of Education, Culture and Science have planned to execute the registration, documentation, inventory making of historical and cultural immovable properties of Mongolia from 2008 to 2015, and it is being implemented since 2008. Aiming to promote the awareness raising on historical and cultural immovable properties among public, the Center of Cultural Heritage has published the photo catalogues including the information and data of fund for registration and information of cultural heritage and materials collected during the research works. The first photo catalogue was published in 2008, including some information of protection and research of immovable properties of Mongolia, and locations on the map, and the list of immovable properties of each soums of Khentii province is attached in the back.

After the publishment of catalogue Khentii, Sukhbaatar province, we have received suggestions from researchers and people about that, to include more information and explanation as possible. Based on this suggestions, more information and explanations were included into the next catalogues of Dornod, Dornogovi Province. Further catalogues will be published like as Dornod, Dornogovi Province.

This time we are introducing to you the revised publishment of photo catalogue include historical and cultural immovable properties of Khentii province. For this publishment of the catalogue historically, culturally, and scientifically valuable immovable properties locate in Khentii province were selected, including their brief descriptions and locations on the map, and the list of immovable properties of each soums of Khentii province is attached in the back. And with brief information of state policy, decision, undertaken activities on protection of immovable properties were included in the catalogue, also with information of research.

The photo catalogue is not for the academic use, it is to promote the public awareness for the better understanding of importance of preserving historical and cultural immovable properties. Dear readers, if you have any suggestions, criticisms or if you want to find out more about the historical and cultural immovable properties of Mongolia, please contact us through the address of our organization.
We believe that you by reviewing this photo catalogues, would greatly contribute for protection and preservation of our immovable properties and pass on to our future generations.

Authors

# УДИРТГАЛ

Өнөөгийн дэлхий нийт хүн төрөлхтний түүхэнд бүтээгдэж бий болсон эдийн болон оюуны соёлын өвийг уламжлагдаж ирсэн хэлбэрээр нь биет ба биет бус соёлын өв хэмээн ангилан авч үзэж байна. Биет бус өвд оюуны соёлын бүхий л өв хамаарах бол биет өвд материаллаг түүхий эдээр бүтээгдсэн бүх дурсгал хамаарах ажээ. Биет соёлын өвийг хадгалагдаж буй орчин нөхцөл, эх төрхөөр нь хөдлөх ба үл хөдлөх гэж хоёр хэсэгт хуваадаг байна.

1972 онд НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар баталсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци”-д “Соёлын өв” гэдэг ойлголтыг үл хөдлөх гэдэг утгаар нь гурав ангилсан байдаг. Үүнд:

- Хөшөө дурсгал (түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан, бүх талын үнэт ач холбогдол бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдвор, бичээс, агуй болон цогцолбор дурсгал)
- Архитектурын чуулга (түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгын цогцолбор)
- Дурсгалт газар (хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд, мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутаг) гэж ангилсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр нь нэн эрт цагаас хүн нутаглаж ирсэн өлгий нутгийн нэг, Төв Азийн эртний нүүдэлчдийн соёл иргэншлийн гол төв болж байсан учир тэдний бүтээн бий болгож үлдээсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалаар үлэмж баялаг орон юм. Манай улс 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын соёлын өвийн талаарх нийтлэг ойлголтод нийцүүлэн 2001 онд шинэчлэн найруулж баталсан “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 3 дугаар зүйлд “... эртний хүний оромж, отог бууц, оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга, ашигт малтмал олборлож, боловсруулж, үйлдвэрлэл эрхэлж байсан газар, булш хиргисүүр, бунхан, оршуулга, тахилын газар, хөшөө чулуу, хадны сүг зураг, бичээс зэрэг археологийн дурсгал; эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз болон уран барилгын цогцолбор, сүм дуган, хийд, гудамж, талбай, байшин барилга зэрэг уран барилгын дурсгал; түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой байшин барилга ..., түүх, соёлын цогцолбор газар; эртний хүн, амьтан, бичил биетэн, ургамлын чулуужсан олдвор, ул мөр, тэдгээрийг агуулсан олдворт газар” зэрэг дурсгалуудыг үл хөдлөх гэх ангилалд хамаатуулан хуульчилсан байдаг.

Аливаа соёлын өв, тэр дундаа түүх, соёлын үл хөдлөх дурсгал бол тухайн улс орны соёлын түвшинг илэрхийлэх том үзүүлэлт болохын сацуу тусгаар тогтнолын баталгааны нэг гол баримт болдог. Энэ ч утгаараа хөдөө хээр оршин буй бүх төрлийн үл хөдлөх дурсгалт зүйлсээ хайрлан хамгаалах явдал бол ямар ч төр засгийн анхаарлын төвд байх ёстой асуудал юм.

**Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах хууль, эрхзүй:** Монголчууд эртнээс өөрсдийн болон бусдын өвөг дээдсийн бий болгож бүтээсэн түүх, соёлын аливаа дурсгалд хүндэтгэлтэй хандаж олон арга хэлбэрээр хамгаалж ирсэн баялаг уламжлалтай ард түмэн. Түүхийн шаралсан хуудсанд “эртний булш, хиргисүүрийг ухаж сүйтгэсэн хүнийг тодорхой тооны адуу малаар торгох зэрэг шийтгэл оноож байсан” тухай цөөнгүй баримт тохиолддог. Түүнчлэн үр хүүхэддээ эртний дурсгалт зүйлийг хөндвөөс “чөтгөр сэрнэ, чөтгөр дагана, сүнс нь хорогдоно, нүд чинь сохорно, гар чинь татна, муу зүйл тохиолдоно...” гэх мэтээр сургаж тэдгээрт аль болох хүндэтгэлтэй хандах сэтгэлтэй болгон хүмүүжүүлдэг байсан уламжлал эдүгээ ч хөдөө орон нутаг бий.

Монгол улсад соёлын өвийг хамгаалах талаар төрийн цэгцтэй бодлого Ардын хувьсгал ялсны дараагаас боловсорч иржээ. 1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн дүрэмд “дэлхий дахины улсын бичиг судрын сан ба музей үзмэрийн зүйлийг хураах... монгол үндэстэнд холбогдох бичигтэй хөшөө, чулуун зураг зүйлүүдийг хамгаална” гэж заасан байдаг нь төрөөс соёлын өвийн талаар баримтлах анхны эрхзүйн баримт болжээ. 1941 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын тогтоолоор “Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг батлан гаргаж улс орон даяар мөрдүүлжээ. Уг дүрэмд “Монгол улсын хязгаар дотор буй хуучны бүх дурсгал болох зүйл цөм Монгол улсын өөрийн хөрөнгө мөн” хэмээн заасан байдаг. Энэхүү дүрмийн ихэнх зүйл заалт нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалахад чиглэсэн байдгийг дурдууштай.

Дээрх дүрмээс хойш 30 гаруй жилийн турш түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах талаар төрөөс ямар

нэг эрхзүйн баримт бичиг батлан гаргаагүй нь нэг талаас монгол нутгийг бүхэлд нь хамарсан эртний дурсгалуудын талаарх бүртгэл судалгаа дутмаг байсан, нөгөө талаас дэлхий нийтийн соёлын өвд хэрхэн хандах хандлага бүрэн төлөвшиж тогтоогүй байсантай холбоотой юм.

1970 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах тухай хууль” батлагдан гарчээ. Энэ хууль бол монголчуудын хэдэн зууны турш хадгалж ирсэн болон бүтээн туурвиж ирсэн түүх, соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сэргээн засварлах, сурталчилах зэрэг бүхий л харилцааг цогцоор нь зохицуулсан бие даасан анхны хууль байв. “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” батлагдан гарснаар урьд өмнө ард иргэдийн дунд үнэ цэнэ, ач холбогдол нь төдийлөн танигдаагүй байсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх ойлголтыг өөрчилж хүн бүрийг эдгээр дурсгалд хүндэтгэлтэй хандах, хадгалж хамгаалах үйл ажиллагаанд гар бие оролцох зэргээр үүрэг хариуцлагатай байх нөхцлийг бүрдүүлсэн юм. Хуулийн хүчин төгөлдөр үйлчилж байсан 1970-1994 оныг хүртэлх хугацаанд Монгол улсын төр түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг шинээр нээж бүртгэх, судлах, сэргээн засварлах чиглэлээр жил алгасалгүй олон ажил зохиож, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг жил бүр нэмэгдүүлж байв. Энэ 20 гаруй жилийн туршид төрөөс авч хэрэгжүүлсэн олон ажлын үр дүн болон соёлын өвөө эрхэмлэн дээдлэгч хүмүүсийн уйгагүй хөдөлмөрийн үр шим Монголчуудыг дэлхийд гайхуулах соёл иргэншилтэй ард түмэн болохыг батласан юм.

Манай улс 1990 оноос дэлхий нийтийн хөгжлийн замд эргэлт буцалтгүй орж урьд өмнө үйлчилж байсан хууль, эрхзүйн баримтуудаа олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчлэн баталж эхэлсэн билээ. 1992 онд УИХ-аас баталсан шинэ Үндсэн хуулинд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасан билээ. Энэ үзэл баримтлалд нийцүүлэн 1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргаж улс орон даяар мөрдүүлж эхэлсэн байна. Энэ хууль нь зах зээлийн харилцаанд шилжиж байсан манай улсын хувьд түүх, соёлын дурсгалын талаарх харилцааг зохицуулах гол хууль болоод зогсохгүй түүнээс хойш батлагдан гарсан олон хуулийн түүх, соёлын дурсгалтай холбоотой заалтыг нөхөхөд чухал эрхзүйн баримт болж байжээ. 1994 оны “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-д хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийсний эцэст 2001 онд утга соёлын өвтэй холбоотой харилцааг зохицуулсан заалтуудыг нэмж “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болгон батлан гаргаж эдүгээ хүртэл мөрдөж байна. Энэ хууль нь монголчуудын соёлын өвийг анх удаа цогц байдлаар нь хамгаалах хуулийн орчин бий болгосноороо түүхэн ач холбогдолтой болсон юм.

Эдүгээ монгол улс түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт, судалгаа, ашиглалттай холбогдолтой харилцааг “Соёлын өвийг хамгаалах тухай” болон “Соёлын тухай”, “Газрын тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” зэрэг хуулиудад туссан үл хөдлөх дурсгалтай холбоотой зүйл заалтын дагуу зохицуулж байна. Энэ бүх хуулиудын зохих зүйл заалтууд нь Монгол улсыг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсээ хамгаалах талаар эрх зүйн цогц орчинтой болсныг харуулж байна.

Монгол улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхаж байгаагийн хувьд олон улсын соёлын өвийг хамгаалах чиглэлээр батлан гаргасан баримт бичиг, гэрээ, конвенцид хүндэтгэлтэй хандаж, хүлээн зөвшөөрч, идэвхитэй оролцсоор ирсэн билээ. Манай улс өнөөдрийн байдлаар 1964 онд “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай” 1954 оны Гаагийн хэлэлцээрт, 1990 онд ЮНЕСКО-ийн 1972 оны “Дэлхийн өвийн конвенци”-д, 1991 онд ЮНЕСКО-ийн 1970 оны “Соёлын эд зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхээс сэргийлэх тухай конвенци”-д, 2005 онд ЮНЕСКО-ийн 2003 оны “Биет бус соёлын өвийг хамгаалах тухай конвенци”-д тус тус нэгдэн орж, эдгээр баримт бичгүүдийн үзэл санаа, үндсэн зарчим, шаардлагуудыг соёлын өвийг хамгаалах хууль, тогтоомжууддаа тусгаж, хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж байна.

**Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, судалгаа:** Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг шинжлэн судлах ажил 1889 онд Оросын эрдэмтэн Н.М.Ядринцевын Орхон голын хөндийд хийсэн хайгуул судалгааны ажлаар эхэлсэн гэж үздэг. Тэр цагаас хойш 120 гаруй жилийн турш Орос, Финлянди, АНУ, Унгар, Япон, Турк, Франц, Герман, Солонгос, Хятад зэрэг дэлхийн олон орны эрдэмтэн судлаачид манай үндэсний боловсон хүчнүүдтэй хамтран эртний түүх, соёлын дурсгалыг түүх, соёл, угсаатны зүй, археологийн шинжлэх ухааны онол, арга зүйн дагуу судалсаар иржээ. Энэ ажлуудын үр дүнд монгол орны нутаг дэвсгэр дээр байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлс нь хүн төрөлхтний хөгжлийн түүхийн салшгүй нэг хэсэг, өвөрмөц соёл иргэншипийн улбаа болохыг баталжээ. Түүнчлэн үл хөдлөх дурсгалын

арвин баялаг мэдээллийн санг бий болгосон байна.

Аливаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах ажил бол тухайн дурсгалыг хадгалж хамгаалах чиглэлээр явуулж буй анхан шатны ажил юм. Дурсгалын хэлбэр төрх, хэмжээ, орчны нөхцөл байдал, ашиглалтын байдал, эвдрэл гэмтэл зэргийг нарийвчлан тодорхойлж, гэрэл зураг, дүрс бичлэг, гар зургаар баримтжуулан мэдээлэл цуглуулах явдал бол бүртгэн баримтжуулах ажлын гол зорилго болно. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг үнэн зөв бүртгэж баримтжуулснаар соёлын өв, түүний үнэ цэнэ, хувьсал өөрчлөлтийн талаар тодорхой мэдээлэл олж авах, хүмүүсийн соёлын өвийг хадгалж хамгаалах хүсэл сонирхолыг нэмэгдүүлэх, тэдний оролцоог дээшлүүлэх, соёлын өвд гарч буй өөрчлөлтийг хянах боломжоор хангагдах, төрийн байгууллагуудыг бодит мэдээллээр хангах зэрэг олон ач холбогдол давуу талтай юм.

Монгол улсын хувьд түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэж баримтжуулж мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 1921 оны ардын хувьсгалын дараахнаас эхэлсэн юм. 1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн дүрэмд хуучны түүх, соёлын дурсгалыг бүртгэж баримтжуулах, хамгаалах үүрэг туссан байдаг. Энэ үүргийнхээ дагуу 1922 онд Судар бичгийн хүрээлэнгээс эрхлэн өнөөгийн Төв, Архангай, Булган, Өвөрхангай аймгийн нутгаар хайгуул шинжилгээний ажил хийж Сарьдагийн хийд, Эрдэнэзуу, Баруун хүрээ зэрэг уран барилгын дурсгалыг бүртгэж гэрэл зургаар баримтжуулж байжээ. Судар бичгийн хүрээлэн 1935 оноос эхлэн хошуудад орон нутаг судлах товчоо байгуулан өөрийн төлөөлөгчийг сонгон суулгаж, идэвхитэй гишүүдийг элсүүлэх ажил зохион байгуулж, түүх, соёлын дурсгалын тухай мэдээ арвин ихээр цуглуулж хуримтлуулж байжээ.

Судар бичгийн хүрээлэнд 20-иод жилийн турш хуримтлагдсан түүх, соёлын дурсгалын талаарх мэдээ сэлт, бүртгэл судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй эмхлэн цэгцэлж “Монгол Ард Улсын археологийн картын сан” зохиох ажлыг 1941 оны сүүлээр ШУХ-ийн Түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан Х.Пэрлээ тэргүүлэн хийж жил бүрийн археологийн хайгуул малтлага судалгааны үр дүнгээр байнга нэмэн баяжуулсаар байжээ. Энэ сан бол Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл-мэдээллийн анхны сан байсан бөгөөд эдүгээ ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн санд хадгалагдаж байна.

Монгол улсад соёлын өвийг бүртгэн баримтжуулж мэдээллийн сан бүрдүүлэх нэгдсэн тогтолцоо 1996 оноос бүрдэж эхэлсэн гэж үздэг. 1994 онд батлагдсан “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай хууль”-ийн 2 дугаар бүлэгт Монгол улс нь түүх, соёлын дурсгалын Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан /УНБМС/-тай, тэр нь шаталсан тогтолцоотой байхаар орсон байна. Энэ заалтын дагуу “Соёлын өвийн төв байгуулах тухай” Соёлын сайдын 1996 оны 07 дугаар тушаал гарч Музейн үзмэр сэргээн засварлах урлангийн орон тоо, төсөвт багтаан түүх, соёлын дурсгалт зүйлийн УНБМС-г байгуулахаар шийдвэрлэжээ. Энэ сан тухайн үеийн Соёлын яаманд цуглараад байсан түүх, соёлын дурсгалт зүйлстэй холбоотой судалгаа, тайлан, мэдээ зэрэг эх хэрэглэгдэхүүнийг татан авч, анхны бүрдүүлэлтээ хийж байжээ. Эдүгээ соёлын өвийн УНБМС нь олон улсын нийтлэг зарчмын дагуу монгол нутаг дахь соёлын өвийг түүх, соёлын хөдлөх, үл хөдлөх /соёлын биет өв/, утга соёлын /соёлын биет бус өв/ гэсэн 3 хэсэгт ангилж мэдээллийн сан бүрдүүлж байна. УНБМС түүх, соёлын дурсгалын бүрдүүлэлтийг хийхдээ 1996 онд ИКОМОС-ын Ерөнхий Ассамблейн 11 дүгээр хурлаас батлан гаргасан “Дурсгалт газруудыг баримтжуулах ИКОМОС-ын зарчим”-ыг баримтлахын сацуу өөрийн орны онцлогт тохирсон аргачлал боловсруулан ажилладаг.

1996-1999 онд “Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлах бүтээх ажлын хүрээнд хээр хөдөө орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаарх мэдээлэл цуглуулах зорилгоор хэд хэдэн чиглэлээр зохион байгуулсан хээрийн шинжилгээний экспедицид СӨТ-ийн мэргэжилтэн судлаачид гар бие оролцож дурсгалуудын хадгалалт хамгаалалтын байдал, засаг захиргааны харьяалал, эвдрэл гэмтлийн талаар нэлээд мэдээлэл хуримтлуулсан билээ. Энэ мэдээллүүд нь тухайн үедээ УНБМС дахь үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн хэсэгт томоохон мэдээлэл бүрдүүлэлтийн ажил болсон бөгөөд, эдгээр мэдээллийг ашиглаж 1998 онд “Улс, аймаг, нийслэлийн, хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчилж, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийг анх удаа боловсруулан хэрэгжүүлсэн юм.

Өнөөдөр манай улсад ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Нүүдлийн Соёл Иргэншилийг судлах Олон улсын хүрээлэн, Монголын Үндэсний музей, МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхим, МУБИС-ийн Түүхийн тэнхим, Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхим, “Чингэс хаан” дээд сургууль зэрэг мэргэжлийн байгууллагууд хууль, журмын дагуу археологи, палеонтологийн хайгуул,

малтлага судалгаа хийж түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар арвин мэдээлэл хуримтлуулж байна.

**Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал:** УБХ-ын Тэргүүлэгчдийн 1941 оны 79 дүгээр хурлын тогтоолоор "Хуучны дурсгалт зүйлсийг сахин хамгаалах дүрэм"-ийг баталж, түүний 2 дугаар хавсралтад нэр бүхий 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэрэглэлийн хамгаалалтад, 16 дурсгалыг улсын хамгаалалтад байхаар шийдвэрлэжээ. Энэ жагсаалт бол Монгол улс анх удаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалаа төрийн хамгаалалтад авсан түүхэн шийдвэр байсан юм.

1970 онд АИХ-аас "БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль" батлагдан гарсны дараа буюу БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн 1971 оны 420 дугаар тогтоолоор "БНМАУ-ын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалын жагсаалт"-ыг баталж, улсын хамгаалалтад 21 дурсгал, орон нутгийн хамгаалалтад 106 дурсгалт газрыг оруулсан байна. Энэхүү 420 дугаар тогтоолоор улс, орон нутгийн хамгаалалтад авсан дурсгалуудад түүхэн үйл явдал, биe хүмүүсийн дурсгалд зориулан болгосон хөшөө, багана, ханын самбар зэрэг дурсгалыг эртний булш хиргисүүр, хот хэрмийн үлдэгдэл, хүн чулуун болон буган чулуун хөшөө дурсгалтай хамтатган хамгаалалтад авсан байна.

1994 онд УИХ-аас "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль"-ийг шинэчлэн баталсантай холбогдуулан дээрх жагсаалтыг тус хуулийн үзэл баримтлал, нэр томъёонд нийцүүлэн дахин шинэчилжээ. 1994 оны Засгийн газрын 233 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт" нэрээр батлагдсан энэ жагсаалтад нийт 93 дурсгалыг улсын хамгаалалтад, 287 дурсгалыг аймгийн хамгаалалтад байхаар тусгасан байна. Энэ жагсаалтад зөвхөн эртний түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамрагдсанаараа онцлогтой юм.

1995-1997 онд УИХ-аас "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль"-д зарим өөрчлөлт оруулж, шинээр аймаг, сум байгуулснаас болж улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх дурсгалын оршин буй засаг захиргааны нэгжийн нэрийг өөрчлөх шаардлага урган гарчээ. Түүнчлэн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд улсын хамгаалалтад зайлшгүй байвал зохих дурсгал цөөнгүй илэрч олдсон байна. Энэ шаардлагын үүднээс Монгол улсын Засгийн газар 1998 оны 235 дугаар тогтоолоор "Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад 120 дурсгалыг улсын хамгаалалтад, 233 дурсгалыг аймгийн хамгаалалтад тус тус авчээ.

2004 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооноос Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг хүн төрөлхтний соёл, иргэншлийн түүхийн олон улбааг хадгалсан дурсгалтай, тэдгээр нь дэлхий дахинд нийтлэг үнэ цэнэтэй гэж үзэн дэлхийн соёлын өвд бүртгэн авсан билээ. Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь 121,967 га газрыг хамардаг бөгөөд энэ бүс нутагт 100 гаруй дурсгалт газарт 1350 орчим нэгж ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал оршдог байна. Эдгээр дурсгалын дотор өмнө нь улс, аймгийн хамгаалалтад орж байсан цөөнгүй дурсгал хамрагдсан юм.

1994 оны "Түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай хууль"-ийг 2001 онд УИХ-аас "Соёлын өвийг хамгаалах тухай хууль" болгон өөрчлөн найруулж баталсан юм. Монгол улсын нутагт сүүлийн 10 гаруй жил явуулсан археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд түүх, соёл, шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой олон дурсгалыг шинээр нээн илрүүлсэн бөгөөд тэдгээрийг зайлшгүй хамгаалах шаардлага тулгарсан, түүнчлэн зарим дурсгалыг аймгийн хамгаалалтын жагсаалтаас улсын хамгаалалтын жагсаалтад оруулах шаардлага урган гарсан зэргээс үүдэн "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалын жагсаалтыг 2008 онд дахин шинэчлэн баталжээ. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан уг жагсаалтад 175 дурсгалыг улсын хамгаалалтад, 275 дурсгалыг аймгийн хамгаалалтад авахаар оруулсан байна. Энэ жагсаалтад түүх, соёлын ач холбогдол өндөртэй, цаашид хамгаалалтад авч, урт хугацаанд тогтвортой судалгаа, шинжилгээний ажил хийх шаардлагатай 15 дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын жагсаалтаас хасч улсын хамгаалалтын жагсаалтад оруулсан ба шинээр 40 дурсгалыг улсын хамгаалалтын жагсаалтад, 57 дурсгалыг аймгийн хамгаалалтын жагсаалтад тус тус нэмж тусгажээ. Мөн анх удаа палеонтологийн дурсгалт газрыг хамруулсан байна.

**Дурсгалт газрын хамгаалалтын цэс:** 1994 онд батлагдсан "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль"-ийн 16.6 дахь заалтад "Эртний хот, суурины үлдэгдэл, байшин барилга, цогцолбор зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн сүр бараг хадгалах зорилгоор эргэн тойронд нь 0.1-3 км-ийн хамгаалалтын бүсийг Засгийн газар тогтоож болно" гэж заажээ. Энэхүү заалтын дагуу түүх, соёлын үл

хөдлөх дурсгалын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол, улсын хамгаалалтын зэрэглэл зэргийг харгалзан үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоож эхэлжээ. Засгийн газрын 1997 оны 241 дүгээр тогтоолоор Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Монголын эртний нийслэл Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсийг 9,69 км.кв талбайтай байхаар тогтоосон нь анхны хамгаалалтын бүстэй дурсгал болсон юм.

2001 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болгон шинэчлэн баталсан бөгөөд уг хуулийн 17.6, 17.7, 17.8 заалтад түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүс тогтоож байх тухай асуудал хэвээр тусгагдаж, талбайн хэмжээг тогтоосон заалтыг хассан байна. Засгийн газар “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн холбогдох заалтыг үндэслэн:

- 2001 оны 96 дугаар тогтоолоор Гандантэгчинлэн хийд, Гэсэр сүм, Богд хааны ногоон ордон, Чойжин ламын сүм, Дамбадаржаа хийд, Гэр хэлбэрт модон дугануud буюу Дашчойлин хийд, Чин ван Ханддоржийн байшингийн хамгаалалтын бүсийг,
- 2002 оны 71 дүгээр тогтоолоор Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Билгэ хаан, Культегины хөшөө, мөн аймгийн Хотонт сумын нутагт орших Хар балгас, Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын нутагт орших Төвхөн хийд, Төв аймгийн Баян сумын нутагт орших Тоньюкукийн хөшөөний хамгаалалтын бүсийг,
- 2003 оны 190 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушигийн өврийн буган чулууны цогцолбор, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Аваргын балгас, Төв аймгийн нутагт орших Манзуширын хийд, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Дарь-Эхийн сүмийн 2 чулуун баганын хамгаалалтын бүсийг,
- 2004 оны 126 дугаар тогтоолоор Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Баруун хүрээний туурь, Булган аймгийн Рашаант сумын нутагт орших Хөгнө тарнийн дээд доод хийдийн туурийн хамгаалалтын бүсийг,
- 2006 оны 70 дугаар тогтоолоор Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Цогт тайжийн Цагаан байшин, бичигт хөшөө, мөн сумын нутагт орших Хар Бухын балгасны хамгаалалтын бүсийг,
- 2006 оны 123 дугаар тогтоолоор Архангай, Өвөрхангай, Булган аймгийн нутагт орших Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсийг,
- 2009 оны 135 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт орших Эргэлийн зоон палеонтологийн дурсгалт газар, Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших Өнгөтийн цогцолбор дурсгал, Дэлгэрхаан сумын нутагт орших Их Хөшөөтийн цогцолбор дурсгал, Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Өглөгчийн хэрэм, Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгал, мөн аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Балдан Бэрээвэн хийд, түүний орчмын хадны зургийн дурсгал, Дунд Жаргалантын цогцолбор дурсгал, Хэрлэн сумын нутагт орших Цэцэн ханы ордны цогцолбор, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нутагт орших “Өндөр хоршоо” хэмээх түүхт барилга (өнөөгийн Дүрслэх урлагийн музей Б.Д), Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших Ардын Намын Төв Хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан түүхт барилгын (өнөөгийн Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей Б.Д) хамгаалалтын бүсийг тус тус тогтоожээ.

**Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын өнөөгийн байдал, авч буй арга хэмжээ:** Хээр хөдөө орших байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалын өнө удаан жил хадгалагдахад байгалийн болон нийгмийн хүчин зүйлс ихээхэн сөрөг нөлөө үзүүлсээр иржээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь байгаль дээр ил задгай оршиж байдгийн хувьд их бага хэмжээний эвдрэл гэмтлийг өөртөө агуулж байдаг. Ялангуяа чулуун дурсгал нь орчны температурын хэлбэлзлэл, салхи, ус болон химийн идэвхтэй бодисууд, ургамал, амьтнаас ялгарах органик бодисуудын нөлөөгөөр ан цав гарах, хагарч гэмтэх, хуурч унах, үйрч бутрах, зэргээр анхны төрх байдлаа алдаж гэмтдэг байна. Мөн газар хөдлөлт, гал түймэр, үер ус, хүчтэй цасан болон шороон шуурга гэх мэт байгалийн гамшигт үзэгдэл нь дурсгалд сөргөөр нөлөөлж буй байгалийн хүчин болдог ажээ.

Агаарын хэлбэлзэл, салхи нь чулууны бүтцийг сийрэгжүүлж физик өгөршилд оруулахаас гадна өгөршиж суларсан чулууны мөхлөг ан цав хооронд ус (хур тунадас) орж тогтон халуун хүйтний хэлбэлзлийг даган

хайлж хөлдөхдөө тэлж агшин ан цавыг ихэсгэн механик өгөршилт үүсгэсэн байдал манай ихэнх хөшөө чулуун дурсгалд олонтаа тохиолддог.

Түүх, соёлын дурсгалд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлд бусдын соёлыг үл хүндэтгэх, хотжилт суурин иргэншил болон нүүдлийн ахуйг дагасан нөлөөлөл, хүн амын сийрэг байдал, эдийн засгийн хомсдол, үйлдвэржилт, оновчгүй бодлого, төлөвлөлт, шашин шүтлэг, буруу аргаар хамгаалах, сэргээн засварлах, хүний санамсаргүй болон санаатай үйл ажиллагаа зэрэг ордог. Сүүлийн жилүүдэд хүмүүсийн сүсэг бишрэлдээ хэтлэгдэн хөшөө чулуунд элдвийн тос түрхэх, хадаг яндар уяж байгаа нь уг дурсгалын насыг богиносгох хохиролтой үйлдэл болдог ажээ. Тухайлбал хөшөө дурсгалд хадаг яндар уяснаар түүнд чийг хуримтлагдаж агаарын хэмийн нөлөөгөөр чулуулгийн гадаргууд хүчтэй нөлөө үзүүлэх, хорхой шавьж үүрлэн элдэв төрлийн хүчиллэг ялгадас ялгаруулан чулуулгийн мөхлөгт сөрөг нөлөө үзүүлдэг байна.
Соёлын өв, түүх, соёлын дурсгалд хүндэтгэлтэй хандах нийгмийн төлөвшил бүрэлдээгүй энэ үед хадны сүг зураг, эртний хөшөө чулуун дурсгалыг аж ахуйн зорилгоор ашиглах, эртний бичээс, хадны сүг зурган дээр элдэв бичээс бичих, өнгө зүсийг өөрчлөх, нураах, булш, хиргисүүр, тахилын байгууламжийг олз ашиг олох зорилгоор ухах, малтах зэрэг зохисгүй байдал их гарч байна.
Монгол улс өөрийн нутаг дээр байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг анхны хэлбэр төрхөөр нь хадгалан үлдэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх шинжлэх ухааны үндэслэлтэй хамгаалалтын анхны ажлуудыг 1940-өөд оноос эхлэн өнөөг хүртэл хийж иржээ. 1944 онд Эрдэнэ Зуу, Амарбаясгалант зэрэг уран барилгын дурсгалуудыг сэргээн засварлах ажлыг, 1960-1961 онд Чойжин ламын сүм, Богд хааны Ногоон ордон зэргийг сэргээн засварлах ажлуудыг хийсэн байна.

1971 онд Барилгын зургийн төв институтэд “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зураг төсөл, эрдэм шинжилгээний товчоо”-г, 1973 онд Соёлын яамны харьяанд “Түүх, соёлын дурсгалт зүйлийн засварын газар”-ыг тус тус байгуулсан бөгөөд 1976 онд дээрх хоёр газрыг нэгтгэн “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах газар” гэсэн бие даасан байгууллагыг байгуулжээ. Энэ байгууллага 1995 оны хүртэлх хугацаанд Монголын уран барилгын томоохон дурсгалууд болох Эрдэнэ зуу, Амарбаясгалант, Гандантэгчинлэн хийд, Богд Хааны ногоон ордон, Чойжин ламын сүм, Цэцэн ханы ордон, Хачин ламын сүм, Чин ван Ханддоржийн байшин, Алтанбулаг дахь ардын хувьсгалын түүхэнд холбогдох барилга байшин зэргийг мэргэжлийн түвшинд сэргээн засварлаж байжээ. Үүний зэрэгцээ хөдөө орон нутгийн засаг захиргаа өөрсдийн нутаг дэвсгэр дээр байгаа үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах зорилгоор хайс хашаа барих, хаяг самбар байрлуулах зэргээр хөдөлгөөн өрнүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах ажлыг тодорхой бодлого, дэс дараалалтайгаар гүйцэтгэх, түүнд зарцуулж буй хандив, төсөв, хөрөнгийг үр бүтээлтэй зарцуулах зорилгоор “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийг 1999-2005 онд хэрэгжүүлжээ. СӨТ-ийн сэргээн засварлагч, мэргэжилтнүүд түүхэн болон шинжлэх ухаан, урлаг уран сайхны өндөр ач холбогдол бүхий зарим хөшөө дурсгалын хэв дардсыг авах, хуулбар хийж улсын сан хөмрөгт хадгалах, зарим хөшөө чулуун дурсгалд бэхжүүлэлт консерваци хийх зэрэг ажлуудыг энэхүү хөтөлбөрийн хүрээнд хийсэн байна. Мөн сүм хийдийг сэргээн засварлах, хамгаалалтын хашаа, саравч барих, аянга зайлуулагчтай болгох зэрэг олон ажил энэ хөтөлбөрийн дагуу хийгджээ.

Дээрх хөтөлбөрийн хамрах хүрээг өргөтгөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлал, дэд бүтэцтэй уялдуулан сурталчлах, соёлын өвийг сэргээн засварлах мэргэжилтэн бэлтгэх зэрэг асуудлыг иж бүрэн тусгасан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг шинээр боловсруулж Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор баталсан юм. Энэхүү хөтөлбөрийг 2008-2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж, зарим ажлуудыг холбогдох газрууд эхлүүлээд байна.

Монгол Улсын төр засгаас түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр олон ажил боловсруулан хэрэгжүүлж байгаа хэдий ч зарим нэг ашиг хонжоо хайсан ухвар мөчид хүмүүсийн харгайгаар олон дурсгалт зүйлс эвдэн сүйдсээр байгаа билээ. Ийм баримтыг олноор нь дурдаж болно. Сайны хажуугаар саар болсон энэ бусармаг үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад хөдөө орон нутгийн ард иргэдийн туслалцаа дэмжлэг туйлаас чухал болохыг шат шатны Засаг дарга, холбогдох байгууллагууд анхааралдаа авбал зохилтой.

Эцэст нь, эцэг өвгөдийнхөө үлдээсэн түүх, соёлын дурсгалуудад хүндэтгэлтэй хандаж, олон арга хэлбэрээр хайрлан хамгаалж, сэргээн засварлаж хойч үедээ бүрэн бүтнээр нь өвлүүлэн үлдээх явдал бол өнөөгийн монголчууд бид бүхний эрхэм үүрэг мөн болохыг уншигч танд сануулья.

# INTRODUCTION

The diversity of intellectual and physical cultural heritage derived from and created by humanity through the long historic period of time is classified into tangible and intangible cultural heritage by their forms and identities. Intangible cultural heritage is defined as the practices, representations, expressions, knowledge and skills, as well as the instruments, objects, artifacts and associated cultural spaces, and tangible cultural heritage includes all other physical objects such as monuments, historic buildings, statues, museum items and others which have significant historic and artistic value to Mongolia. . Tangible cultural heritage is identified as movable and immovable cultural heritage characterized by their storage, mobility, sizes and associated significance with their origination.

As stated in the 1972 UNESCO "Convention for the Protection of the World Cultural and Natural Heritage" adopted by the 17th General Conference, the "Cultural Heritage" is classified into three subcategories by its immovable distinctions as follows:

- Monuments: architectural works, works of monumental sculpture and painting, elements or structures of an archeological nature, inscriptions, cave dwellings and complex features, which are outstanding universal value from the historic, artistic and scientific point of view
- Groups of building: groups or separate or connected buildings which, because of their architecture, homogeneity or their place in the landscape, are of outstanding universal value from the point of view of history, art or science
- Sites: Works of man or the combined works of nature and of man, and areas including archeological sites which are of outstanding universal value from the historical, aesthetic, ethnological or anthropological points of view)

Mongolia is one of the richest countries with historical and cultural immovable properties, created by and derived from the nomadic people's lifestyle of Central Asia, and transmitted from generation to generation. In 2001, Mongolia has revised its law on "Protect of Cultural Heritage" in accordance with the international cultural heritage protection standards and Mongolian Constitution of 1992. In the 3rd article of the law it states that, "...immovable properties include archeological findings such as shelter of ancient people, cultural layers of ancient settlement, a place used to be used for mining and industry, tumulus, grave, tomb, sacrificial sites, man stone, deer stone, archeological artifacts, rock paintings, rock inscriptions, ancient settlements, ancient ruins, ancient castles, ancient walls, complex of architecture, temples, monasteries, streets, squares (old and related with historical activity), apartments and buildings relevant to individuals and events significant in history, historical and cultural sites, fossils microorganisms, plants ancient animals, and paleontological sites.

State independency and culture is expressed by the cultural heritage, especially historical and cultural immovable properties. It is of utmost importance for our government to pay close attention to protect and safeguard the immovable properties of Mongolia.

**Law and policies on protection of historical and cultural immovable properties:** From the ancient times Mongolians have preserved and protected with respect historical and cultural heritage, created by the ancestors. People were fined with livestock for excavating and damaging ancient tumulus and tombs. Also the elders have been teaching and transmitting knowledge to younger generations about preserving and respecting the immovable historic properties. It is believed that "Those who damages the immovable historic properties inherited from their ancestors, would have bad luck, such as meeting with ghosts; lose eyesight or always having some problems" etc.

In 1921, after the People's Revolution, state policy was formulated for protection of historical and cultural heritage. Institute of Language and Literature has developed its internal policy, that states "Institute to preserve and protect the rock inscriptions and rock paintings in Mongolia". This policy remains as the first Mongolian act for historical and cultural protection. "Protection and Preservation Regulation for Historical and Cultural Heritage" was adopted by the 79th conference decision of Presidium of State Baga Khural in 1941. In the regulation it states that, "The historical and cultural heritage existing on Mongolian territory, shall be in possession of Mongolians". Almost all paragraphs and articles of this regulation adopted for immovable properties protection.
For almost 30 years since the adoption of the above policies Mongolian government didn't make any changes to it neither have adopted any new acts for historical and cultural heritage preservation. Possibly it's due to insufficient research, lack of people's awareness regarding the importance of protecting the historical and cultural heritage.

By the consent of the Presidium of People's Great Khural, the "Law on Protection of Cultural Properties of People's Republic of Mongolia" was adopted in 1970, which was comprehensively and systematically included all cultural functioning relations and activities containing research, examination, conservation, preservation, promotion and dissemination of historical and cultural heritage created by Mongols. As a result, the awareness has risen among

people by the certain degree, changed their attitude towards the cultural heritage and increased their respect and responsibility as well as their contribution on protecting and preserving it. The law was effective from 1970 to 1994, the period of time that Mongolian government has organized number of works for identifying, restoring historical and cultural immovable monuments, along with discovering, registering, conserving and preserving them. Consequently, a number of activities and works were implemented on cultural heritage protection. Thus the outside world gradually started to get to know of Mongolian unique cultural heritage.

Since 1990, Mongolia has been developing democratic society. Accordingly the acts and laws were revised and combined with democratic concepts. Adopted by the State Great Khural, the cultural heritage as defined in the new constitutional law of 1992, “Mongolian people’s historical and cultural heritage, science and intellectual property shall be under the State protection of Mongolia”. In accordance with it, the State Great Khural adopted “Law on Protection of Historical and Cultural Properties” in 1994. The law coordinated number of cultural relations combined with the concepts of democracy. And it defined the criterias of objects to be included into historical and cultural immovable properties. In 2001, after the several amendments made on “Protection Law of Historical and Cultural Properties of 1994”, articles of protection of intangible cultural heritage were added and has changed to the “Protection Law of Cultural Heritage”. Since 2001, the government has been enforcing “Protection Law of Cultural Heritage”, in Mongolia. Cultural heritage protection and preservation is completely coordinated by this law.

Today, cultural heritage issues, particularly immovable monuments matters are coordinated by some articles of the following laws, such as “Protection Law of Cultural Heritage”, “Land”, “Minerals”, “Protected Areas”, “Criminal law” etc.

Mongolia has signed in international agreements, charters and conventions for preserving and protecting the cultural heritage: “1954 UNESCO Convention for the Protection of Cultural Property in the Event of Armed Conflict” in 1964; “1972 UNESCO Convention for the World Cultural Heritage” in 1990; “1970 UNESCO Convention on the Means of Prohibiting and Preventing the Illicit Import, Export and Transfer of Ownership of Cultural Property” in 1991; and “2003 UNESCO Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage” in 2005.

**Registration and research of historical and cultural immovable properties:** The first research and examination work on immovable historical and cultural properties in Mongolia started in 1889, by Russian researcher N.M Yadrintsev at the Orkhon River Valley. Since then, for over a hundred years, Mongolian researchers and scholars have done many research works and examinations on historical and cultural immovable properties based on the archeological and ethnological theories and methods, in cooperation with the researchers and experts of Russia, Finland, USA, Hungary, Japan, France, German, China, Korea and others. As a result of those research works, researchers and experts have come to the conclusion that immovable properties of Mongolia are indeed an important part in the history and culture. Also as a result of these research works, first information and registration database system for immovable properties was created.

Registration and documentation is considered as a primary step for protection of immovable heritage properties. Main objective of the registration and documentation is to identify the current value and status of immovable properties by determining their size, form, recent condition, damages and registering and documenting them by photo, video and hand drawings. By collecting truthful information and making the correct registrations of immovable properties is essential to increase people’s contribution on cultural heritage protection, to collect detailed information on cultural heritage, to examine and control the cultural heritage evolution (to compare past and current status), and to provide the right information to public, relevant government agencies and to raise their awareness.

After the People’s Revolution, immovable properties registration and documentation started in Mongolia by the internal policy of Institute of Language and Literature “Institute for registration, documentation and protection of historical and cultural heritage”. In accordance with it, the Institute has organized research works in Tuv, Arkhangai, Bulgan, Uwurkhangai provinces for registration and digital documentation of the“Sandagiin Khiid”, temple monastery of “Erdene Zuu” and “Baruun Khuree”. Since 1935, the Prefectural Research Centers were established in every province of Mongolia, and representatives and members were appointed. Therefore huge amount of relevant information and documents on historical and cultural heritage were gathered and recovered.

At the end of 1941, under the administration of Mr. Perlee (researcher and scientist of history of Mongolian Academy of Sciences) the Institute of Language and Literature,collected “Archeological information database of Mongolia” and prepared a new form for cultural heritage research materials and information. This work has taken twenty years. And the database was developed and enhanced annually with new data of the archeological excavations and re-

search works. "Archeological information database of Mongolia" was the first registration and information database for cultural heritage, and the data of the database has been kept and saved in Hand Written format at the Institute of Archeology of Mongolian Academy of Science.

The unified system for data and information database for the registration and documentation of historical and cultural heritage was created in 1996. In 1994, the State Great Khural adopted the new "the Law for Protection of Historical and Cultural Properties" combined with new constitution. In second paragraph of this law, it states that Mongolia needs to have a systematic Registration and Information State Database for Cultural Heritage". According to this article, in 1996 Minister of Culture made his 7th order to establish a Center of Cultural Heritage, thus the establishment of the registration and information state database was included in the budget. The database received the first registration and information of historical and cultural heritage from Ministry of Culture, which was previously collected by the Ministry. According to the international general principals, we are collecting historical and cultural heritage information by three basic categories, as movable, immovable and intangible cultural heritage. When we register and document historical and cultural heritage into the database, we refer to comply with ICOMOS Principles for the Recording of Monuments, Group of Buildings and Sites, ratified by the 11th ICOMOS General Assembly in 1996.

Through 1996-1999, in the framework of the creation of "Historical and Cultural Properties of Mongolia" guidebook, specialists and researchers of the Center of Cultural Heritage participated in the number of field research works and collected information on current status for immovable properties and their locality. As a result, most of the immovable properties information was collected into Registration and Information State Database of Cultural Heritage. Consequently, the "List of Protection of Historical and Cultural immovable properties for state, province, city of Ulaanbaatar" was revised, and "National Project for the Protection and Conservation of Historical and Cultural Heritage" was implemented in1998.

Today, the Institute of Archeology, Institute of Paleontology of Mongolian Academy of Science, International Institute for the Study of Nomadic Civilizations, National Museum of Mongolia, Department of Archeology and Anthropology at the School of Social Science, National University of Mongolia, Department of History at Mongolian State University of Education, Department of Archeology at University of Ulaanbaatar and "Chinggis Khaan" university are making legal archeological excavations and research works, and collecting the information for immovable properties.

**Historical and cultural immovable properties in protection of state, province, city of Ulaanbaatar:** "Protection and Preservation Rule for Historical and Cultural Properties" was adopted by the 79th conference decision of Presidium of State Baga Khural in 1941. At its second appendix, the presidium has decided to select 15 immovable monuments as the first degree state protection, 16 immovable monuments as a state protection. After adopting the "Law on Protection of Cultural Properties of People's Republic Mongolia" in 1970, by the 420th resolution of 1971 by Council of Ministers of Mongolia, has adopted the "List of Protection of Historical and Cultural Heritage of People's Republic Mongolia", has selected 21 immovable properties for the state protection, and 106 immovable monuments for provincial protection. According to this 420th decision, these immovable monuments include statues built for memorial purposes of historical events and individuals, columns, and with tombs, tumulus, ancient settlements, ancient ruins, man stones, deer stones.

"List of Protection of Historical and Cultural immovable properties of state, province, Ulaanbaatar city" was revised, according to the amendments of "Protection Law of Historical and Cultural Properties" of 1994. At the third appendix of 233rd decision, the Government of Mongolia has decided to select 93 immovable properties as a state protection, 287 immovable properties as a provincial protection, according to the "List of Protection of Historical and Cultural Immovable Monuments of State, Province and city Ulaanbaatar". The list has specific rules for ancient historical and cultural properties.

In 1995-1997, the State Great Khural amended the "Law of Mongolia on Administrative and Territorial Units and Their Governance", and established new administrative units. For this reason, the need to change the name of administrative units was required for the "List of Protection of Historical and Cultural immovable monuments of state, province, Ulaanbaatar city". Also the number of discovered immovable properties by the science and research organizations were required to be included in the state protection. In 1998, by the 235th decision of Government, the "List of Protection of Historical and Cultural immovable monuments of state, province, Ulaanbaatar city" was revised. In accordance with it, 120 immovable properties were selected for the state protection, 233 immovable properties were selected for provincial level protection.

In 2004, the UNESCO World Heritage Committee inscribed Orkhon Valley Cultural Landscape on World Heritage

List, including valuable historical and cultural heritages of human history. Orkhon Valley Cultural Landscape has over 100 cultural sites and about 1350 historical and cultural immovable properties, covering area of 121,967 hectares. Orkhon Valley Cultural Landscape has number of immovable properties selected to state and provincial protection.

“The Law for Protection of Historical and Cultural Properties of 1994” has been revised and changed to “the Law for Protection of Cultural Heritage” by the State Great Khural in 2001. As a result of the past 10 years archeological excavations and research works, the number of cultural properties were discovered, and further protection was required for the preservation of those properties. In accordance with it, the “List for Protection of Historical and Cultural immovable properties of state, province, Ulaanbaatar city” was revised by the government in 2008. On May 14th of 2008, the protection list has been revised by the 175th resolution of Government, and 175 immovable properties were selected as the state protection, 275 immovable properties are under province protection. 15 immovable properties are included in the state protection. 40 immovable monuments are under the state protection, 57 immovable monuments under province protection. And for the first time, paleontological sites were selected in the protection list of the state and province.

**Protection zone of immovable properties:** In Paragraph 6 of article 16, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994”, “Government has set up 0.1-3 kilometers of protection zone around the historical and cultural immovable properties, such as remains of ancient cities and settlements, buildings, architecture complexes in order to provide the integrity and safety thereof ”. In accordance with this article, setting up protection zones around the immovable monuments oversaw their significance on history, culture, science and classification on state protection. By the 241st resolution of Government in 1997, first protection zone was set up around ruins of Kharkhorum city, capital of Mongolian Empire, covering an area of 9.69 square kilometers.

The “Protection law of Historical and Cultural Properties of 1994” revised and changed to “Protection law of Cultural Heritage” by the State Great Khural, in 2001. Paragraphs 6, 7, 8 of article 17, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994” re-entered into “Protection Law of Cultural Heritage” and the article for measurement of surrounding areas was removed

- By the 96th decision of 2001, the protection zones were set up around the Gandantegchinlen Khiid monastery, Monastery Geser, Green Palace of Bogd Khaan, Temple of Choijin Lama, Temple of Dambadarjaa, Temple of Dashchoilon (Wooden temples), Apartment of Chin Van Khanddorj.
- By the 71st decision of 2002, protection zones were set up around the inscripted monument for Bilge Khan, memorial complex of Kul Tegin in Khashaat soum of Arkhangai province, ruins of Khar Balgas in Khotont soum of Arkhangai province, Tuvkhun Monastery in Bat- Ulziit soum of Uwurkhangai province, inscriptions monument of Tonyokuk in Bayan soum of Tuv province.
- By the 190th decision of 2003, the protection zones were set up around the complex of deer stone called place of Uushgiin Uwur in Burentogtokh soum of Khuvsgul province, ruins of Avarga in Delgerkhaan soum of Khentii province, temple of Manzushir in Tuv province, 2 stone columns of monastery Dari-Ekh in Baynzurkh district of Ulaanbaatar city.
- By the 126th decision of 2004, the protection zones were set up around the ruins of Baruun Khuree in Kharkhorin soum of Uwurkhangai province, remains of 2 temple s of Khugnu Tarni in Rashaant soum of Bulgan province
- By the 70th decision of 2006, protection zones were set up around the inscriptions monument and building remains of Tsogtiin Tsagaan baishin, ruins of Khar Bukh in Dashinchilen soum of Bulgan province
- By the 123rd decision of 2006, the protection zones were set up around the Orkhon Valley Cultural Landscape as inscribed on World Heritage List, in Arkhangai, Uwurkhangai, Bulgan province
- By the 135th decision of 2009, the protection zones were set up around the paleontological sites of Ergeliin Zoon in Khatanbulag soum Dornogobi province, complex monuments of Ungut in Altanbulag soum Tuv aimag, complex monuments of Ikh Khushuut in Delgerkhaan soum Khentii province, complex monuments Uglugchiin Kherem, Rashaan Khad, Uzuur Tsohio in Batshireet soum of Khentii province, Baldan Bereeven temple and rock paintings in Umnudelger soum of Khentii province, complex monuments of Dund Jargalant, complex of Tsetsen Khan palaces in Kherlen soum of Khentii province, historic building called “Undur Khorshoo” (recent Fine Art Museum) in Chingeltei District of city Ulaanbaatar, historical

building of Central Committee of People's Party and People's Government (recent Museum of the History of Ulaanbaatar).

**Current status and implementation of works of the protection of historical and cultural immovable properties:** Many of our historical and cultural immovable properties have already been destroyed by the human activities and natural and weather decays.

Stone monuments are damaged, cracked, disintegrated by water, wind, chemical substances and bacterial damages, which penetrates pores and capillaries of stone. And natural disaster as a quake, fire, water flood, snow and dust storm has damaged stone monuments. Most of the all immovable properties in Mongolia have damaged by water and component became more porous.

Social factors, such as disrespect to culture, urbanization, economic crisis, sparse population, industrialization, illogical policy, irrational planning, religious issues, wrong conservation and protection, human improper activities are damaging historical and cultural heritages.

Recently, physical damages of immovable properties have increased substantially, due to people's worship ceremonies. When people worship, they offer and spray milk, butter oil on stones, and wrap them with silk scarf, which have resulted in destruction of these stone monuments.

Today, social behavior has developed disrespect for historical and cultural heritage, people are making illegal excavations to find profits, that also causes destruction and damage for the immovable monuments. Also writing letters or drawing images and symbols on ancient rock inscriptions and rock paintings take place.

Since 1940, Mongolia has been organizing number of research and conservation works on protection of immovable properties. In 1944, monastery Erdene Zuu and temple Amarbaysgalant were conserved and restored. In 1960-1961, temple of Choijin Lama, Green Palace of Bogd Khaan were conserved and restored as well.

In 1971, the "Agency of Academy for Research and Scheme Planning of Historical and Cultural Property" was established in the Central Architectural Institute. In 1973, the "Restoration Laboratory of Historical and Cultural Property" was established under the Ministry of Culture. In 1976, both organizations had united under the name of "Conservation and Restoration Laboratory of Historical and Cultural Property". Since that time until 1995, the organization have conserved many architectural buildings, such as Erdene Zuu, Amarbaysgalant, Gandantegchinlen, Green Palace of Bogd Khaan, temple of Choijin Lama, complex of Tsetsen Khan palaces, monastery of Khachin Lama, apartment of Chin Van Khanddorj, historic buildings in Altanbulag relevant to the People's Revolution etc. Also local administrations have built fences, put introduction boards near the immovable monuments for protecting them.

Through 1999-2005, the "National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties" was implemented, organizing a systematic conservation and preservations of historical and cultural immovable properties.

Within the framework of this project, Center of Cultural heritage and its conservators and specialists have conserved and preserved immovable monuments, made copies and replicas of monuments for the storage in the state fund, which are of significant historical and scientific value to Mongolians. And in the framework of this project, number of works have been implemented, such as building fences, conserving monastery and temple buildings, setting up lightening arresters etc.

In 2007, the "National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties" adopted by the 303rd decision of government, for promoting the immovable properties combined with the infrastructure and tourism, and to build capacity of conservators on cultural heritage conservation. The project is planned to be implemented from 2008 till 2015. The work has started. .

Mongolian government is implementing number of works on protection of historical and cultural immovable properties, but it was being destroyed and damaged by the improper activities of people. To stop and prevent this illegal activities on historical and cultural immovable properties, the support of local people is essential.

In the end, we should always remember that our main priority and responsibility is to respect and protect our historical and cultural heritage and pass it on to the future generations.

# ХЭНТИЙ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Хэнтий аймаг нь Монгол орны зүүн хойд хэсэгт зүүн талаараа Дорнод аймагтай, зүүн урд талаараа Сүхбаатар аймагтай, урд талаараа Говьсүмбэр, Дорноговь аймагтай, баруун талаараа Төв аймагтай, баруун хойд талаараа Сэлэнгэ аймагтай, хойд талаараа ОХУ-ын АБНАУ-тай тус тус хиллэн 80.3 мян.км2 газар нутаг эзлэн оршдог. Аймгийн төв нь Өндөрхаан хот, Улаанбаатар хотоос 331 км зайтай.

Хэнтий аймгийн газар нутаг нь Ардын хувьсгалаас өмнө Халхын Сэцэн хан аймагт, 1923 оноос Хан Хэнтий уулын аймагт тус тус харьялагдаж байжээ. УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор Хан Хэнтий уулын аймгийг өөрчлөн зохион байгуулахад Хэнтий аймгийг 19 сумтайгаар байгуулсан байна. 1942 онд Сүхбаатар аймгийг шинээр байгуулахад тус аймгийн сумдаас 4 сумыг шилжүүлэн өгчээ.

Хэнтий аймгийн газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн дундаж температур нь -19° - -23°С, зуны дундаж температур +16° - +21°С, жилд дунджаар 170-210 мм хур тунадас унадаг. Аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг гүвээ, толгод, тал хээр газар эзэлдэг бөгөөд нутгийн хойд хэсэгт Хан Хэнтийн нурууны салбар уулс оршдог. Аймгийн нутгаар Хэрлэн, Онон, Туул, Улз, Барх, Жаргалант, Хурх, Тэрэлж зэрэг гол мөрнүүд урсах ба Хангал, Хөх, Гүрэм зэрэг томоохон нуурууд бий.

Өнөөдөр Хэнтий аймаг Батноров, Батширээт, Баян-Адрага, Баянмөнх, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Галшар, Дадал, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн, Цэнхэрмандал гэсэн засаг захиргааны 17 сум, орон нутгийн 3 хот, 83 багтай. Тус аймагт халх, буриад ястнууд зонхилсон 70.2 мянган /2009 оны байдлаар/ ард иргэд оршин сууж амьдарч байна.

Хэнтий аймгийг 1943 онд “Алтан гадас” одонгоор шагнаж байжээ.

Хэнтий аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж судалсан тухай тойм. Хэнтий аймгийн нутагт нь суут богд Чингис хааны төрж өссөн түүхэн газар төдийгүй монголчуудын нэн эртнээс нааш төвхнөн ирсэн голомт нутаг юм. Тийм ч учраас газрын хэвлийд нь хадгалагдан үлдсэн түүх, соёлын дурсгалууд дотоод гадаадын олон эрдэмтэн судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байдаг юм. 1896 онд Дорнод Монголоор аялан явж байсан Д.А.Клеменц өнөөгийн Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Бургастайн Бичигт цохионд сийлсэн нэгэн бичээсийг үзэж өөрийн тайландаа тэмдэглэн үлдээжээ. Мөн 1927 онд Зөвлөлтийн судлаач А.А.Амстердамская одоогийн Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Гэлэн чулуун” хэмээх хүн чулуун хөшөөг үзэж тодорхойлон гар зургийг үйлдэж тайландаа хавсаргажээ. Эдгээр баримт бол тус бүс нутгийн түүх, соёлын талаарх цөөн хэдэн судалгааны хэрэглэгдэхүүн юм.

Хэнтий аймгийн нутагт буй түүх, соёлын дурсгалыг бүртгэж судлах ажил 1940-өөд оноос эхэлсэн байна. Монголын ууган археологич Х.Пэрлээ 1940-өөд оноос эхлэн Хурх, Жаргалант, Хэрлэн голын сав дагуу орших эртний түүх, соёлын дурсгалыг тодорхойлон бүртгэж, 1950-иад оны эхнээс зарим дурсгалыг малтан шинжилж эхэлжээ. Академич Х.Пэрлээ 1950-1980 онд Хэнтий аймгийн бараг бүх сумын нутагт археологийн хайгуул малтлага судалгааны ажил хийхдээ олон дурсгалыг шинээр илрүүлж судалгааны эргэлтэнд оруулсан бөгөөд энэ ажлынхаа үр дүнг нэгтгэн 5 нэгэн сэдэвт зохиол, олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна.

1961 онд Шинжлэх Ухааны Академи байгуулагдаж, түүний бүрэлдэхүүнд Түүхийн хүрээлэнг байгуулснаар монголын түүхийн бүх үеийг үе шаттай, системтэй өргөн хүрээгээр судлах боломж нээгдсэн билээ. Энэ цаг үеэс хойш монголын өргөн уудам нутгийг бүхэлд нь түүх, археологи, угсаатны зүйн хувьд судлан шинжлэх ажил хүрээгээ тэлж, гадаадын эрдэмтэн судлаачидтай хамтарсан болон үндэсний боловсон хүчнүүдээс бүрдсэн экспедицүүд олноороо ажиллах болжээ.

1966-1975 оны үед Д.Наваан Гурван голын шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд орж, Дорнод монголын дөрвөлжин булшийг судлах явцдаа Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Баянмөнх, Баянхутаг, Идэрмэг /өнөөгийн Батноров сумын нутаг Б.Д/, Баян-Овоо сумдын нутаг буюу Хэрлэн голын сав, Батширээт, Дадал сумын нутаг буюу Онон голын савд орших дөрвөлжин булшнуудаас нэлээдийг малтан судалж түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олон арван олдворыг олжээ. Доктор Д.Наваан судалгааны ажлын үр дүнгээ нэгтгэн 1975 онд “Дорнод Монголын хүрлийн үе” хэмээх нэгэн сэдэвт зохиолоо хэвлүүлсэн билээ.

1969 онд Гурван голын шинжилгээний анги Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутаг Дуулга уулын өврөөс

Хүннүгийн үед холбогдох 140 гаруй булшийг илрүүлэн олж 5 булшийг малтан судалжээ. Энэхүү дурсгалыг дараа нь 1971 онд Монгол-Унгарын шинжилгээний анги, 1975, 1985 онд МЗТСХЭ-ийн хүрэл, төмөр зэвсгийн дурсгал судлах анги, 1988 онд Монгол-Зөвлөлт-Унгарын хамтарсан Хүннүгийн дурсгал судлах ангийхан очиж давтан судалж, хэд хэдэн булшийг малтан судалсан байна.

1990-1992 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төсөл Чингис хааны онгоныг эрж хайх зорилгоор 3 жил дараалан Төв, Хэнтий аймгийн нутагт өргөн хүрээтэй судалгааны ажлыг зохион байгуулсан билээ. Энэ төслийн хүрээнд Монгол, Японы эрдэмтэн судлаачид /археологийн судалгааг Монголын талаас профессор Д.Цэвээндорж, Японы талаас профессор Ш.Като нар ахлан ажиллажээ/ Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Дэлгэрхаан сумдын нутагт нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийж, 3586 ш булш, хиргисүүрийг бүртгэж баримтжуулжээ.

1992 онд Дорнод монголын экспедицийн хүрээнд археологч З.Батсайхан, Д.Эрдэнэбаатар нар Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутагт хайгуул хийж, дөрвөлжин булш, монгол булш хэд хэдийг малтан шинжилжээ. Энэ судалгааны үр дүнд хүрлийн үеийн нүүдэлчдийн хэрэглэж байсан аж ахуй, соёлын олон сонирхолтой олдворууд илэрч олдсон байна.

Хэнтий аймгийн нутагт буй түүх, соёлын цөөнгүй дурсгалаас олон жил давтан судлагдаж буй олон дурсгал бий. Жишээлбэл Х.Пэрлээ тус аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Рашаан дэрсний балгасыг 1961 онд илрүүлж 1966, 1967, 1976 онуудад тус тус малтан шинжилжээ. 1992 онд уг балгасыг Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хүрээнд геофизикийн нарийн судалгаа хийж дэвсгэр зургийг нь анх удаа үйлдсэн байдаг. 2001 оноос мөн Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн хүрээнд уг дурсгалт газрыг нарийвчлан судлах хийгээд авран хамгаалах чиглэлээр олон ажлыг зохион байгуулсаар байна. Мөн Рашаан хадны орчмын олон үеийн дурсгалыг доктор Х.Пэрлээ анх судалгааны эргэлтэнд оруулсан бөгөөд түүнээс хойш тус дурсгалт газар 1973, 1974 онд Гурван голын шинжилгээний анги, 1979, 1980, 1981 онуудад Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедиц /МЗТСХЭ/ малтлага судалгааны ажил хийсэн ажээ.

Хэнтий аймгийн нутагт эртний түрэг, араб, монгол, төвд, хятад, дөрвөлжин, кидан үсгээр, улаан зос, хар бэх ашиглан бичсэн болон сийлсэн олон үед холбогдох бичгийн дурсгал нэлээд бий. Эдгээр бичгийн дурсгалуудыг академич Б.Ринчин, Х.Пэрлээ, судлаач М.Шинэхүү, доктор Ц.Шагдарсүрэн, Б.Сумъяабаатар, Л.Болд, А.Очир, Ц.Баттулга, Зөвлөлт-Оросын эрдэмтэн С.Г.Кляшторный, Японы эрдэмтэн Ш.Като, Хятадын эрдэмтэн Фэн Цзя Шэн нарын зэрэг дотоод, гадаадын олон эрдэмтэн судлаачид судалж тайлж уншсан байна. Өнөөдрийн байдлаар тус бүс нутагт 10 орчим газраас нийт 70 гаруй бичгийн дурсгал илэрч мэдэгдэн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Монголын нэрт газарзүйч, эрдэмтэн О.Намнандорж 1960-1980-аад оны дунд үе хүртэл Хэнтий аймгийн нутагт хээрийн шинжилгээний ажлаар явахдаа зам зуурт тааралдаж байсан түүх, соёлын дурсгалыг бүртгэж, товч тодорхойлолт бичиж байжээ. Тэрээр “Монголын түүх, соёлын дурсгал” сэдэвт бүтээлдээ Хэнтий аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1974 оны 12 дугаар тогтоолоор хамгаалалтад авсан дурсгалт зүйл дээр нэмж тус аймгийн нутаг дэвсгэр дээр орщдог олон тооны булш, бичигт хад, хөшөө чулуудыг бичжээ. О.Намнансүрэн хээр хөдөө орших түүхийн дурсгалуудыг бүртгэж тэмдэглэхээс гадна тэдгээрийг хэрхэн хамгаалах, сэргээн засварлах талаарх асуудлыг хөндсөн цөөнгүй өгүүлэл, нийтлэл бичсэн юм.

1996-1999 онд Г.Гонгоржав, Г.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг “Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлах бүтээх ажлын хүрээнд Хэнтий аймгийн нутагт ажиллаж олон тооны дурсгалыг давтан болон шинээр бүртгэж, гэрэл зураг, гар зураг дүрс бичлэгээр баримтжуулсан байдаг. Тэдний цуглуулсан үл хөдлөх дурсгалтай холбоотой мэдээ баримт, эх хэрэглэгдэхүүн эдүгээ СӨТ-ийн УНБМС-д хадгалагдаж байна.

2003 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Цогтбаатар, Ч.Амартүвшин, магистр Ж.Гантулга, Д.Болдхуяг, Б.Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй хайгуул судалгааны анги “Их засаг” их сургуулийн дэмжлэгтэйгээр Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэний Хөдөө арал орчимд нарийвчилсан хайгуул судалгаа хийж эртний түүх, соёлын дурсгалуудын байршлыг тогтоон, тус бүс нутагт орших үл хөдлөх дурсгалын талаар мэдээллийн сан бүрдүүлсэн байна.

2005 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал доктор, профессор Д.Цэвээндоржоор ахлуулсан хайгуул судалгааны анги Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдын зааг, Хэрлэнбаян-Улаан уулын орчимд хайгуул судалгааны ажил гүйцэтгэж олон үед холбогдох булш, тахилын байгууламж шинээр илрүүлэн олж баримтжуулжээ.

2006-2008 онд Монгол-Японы хамтарсан “Дорнод Монголын чулуун зэвсгийн судалгаа” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутагт хайгуул судалгаа хийж, неолитын үед холбогдох хэдэн зуун чулуун зэвсгийн үлдэгдэл бүхий цөөнгүй дурсгалт газрыг илрүүлж баримтжуулсан байна. Дээрх судалгааны ажилд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч доктор, дэд профессор Б.Цогтбаатар, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Болорбат, Ц.Амгалантөгс, Д.Одсүрэн нар оролцон ажиллажээ.

2008 онд МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн тэнхмийн багш доктор, профессор Д.Наваан, Д.Түмэн, М.Эрдэнэ, Д.Хатанбаатар нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний анги “Дорнод Монгол” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт орших Сэрвэн хаалга уулын орчимд археологийн хайгуул судалгаа хийж хүрлийн үед хамаарах булшнуудын байршлыг тогтоон дэвсгэр зургийг үйлджээ.

Хэнтий аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт. Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалаас 1941 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлаас батлан гаргасан “Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийн “улсын нэгдүгээр зэрэгт орох дурсгалын бүртгэлд Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дээрх дурсгалуудаас Батширээт сумын нутагт буй Өглөгчийн хэрмийг “Чингисийн цамхаг ба хэрэм” нэрээр оруулсан байдаг.

1970 онд АИХ-аас “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргаж улс орон даяар мөрдүүлж эхэлснээр эх орны түүхэнд холбогдол бүхий хуучны дурсгалт зүйлийг хамгаалах сэтгэлгээ ард иргэдийн ухамсарт сууж, тэр хэмжээгээр түүх, соёлын дурсгалыг хамгаалах ажил газар сайгүй өрнөж эхэлсэн байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн 1971 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалт”-ын улсын хамгаалалтын жагсаалтад тус аймгийн нэг ч дурсгал ороогүй байна, харин орон нутгийн хамгаалтад:

- Биндэр суманд орших Рашаант уулын хадны сүг зураг
- Цэнхэрмандал суманд орших Түрэг бичиг
- Өндөрхаан хотод орших Цэцэн ханы өргөө
- Өндөрхаан хотод орших Зөвлөлтийн дайчдын хөшөө
- Өмнөдэлгэр сумын нутагт орших Хилчин Х.Дамбын хөшөө
- Батширээт суманд орших Өглөгчийн хэрэм ..., гэсэн 6 дурсгалыг оруулан баталжээ.

Дээрх жагсаалт батлагдан гарсны дараа Хэнтий аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1974 оны 12 дугаар тогтоолоор сум, хороо, хотын Гүйцэтгэх Захиргаадын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтыг батлан гаргажээ. Үүнд:

- Батширээт сумын нутагт: Биндэрийн овооны тариа бригадын хойд толгодод байгаа шинэ чулуун зэвсгийн бууц, мөн Өглөгчийн хэрэм,
- Өмнөдэлгэр сумын нутагт: Дунд Жаргалантын амны хүрэл зэвсгийн үеийн хөшөө. Гандан Бэрээвэн хийдийн барилгуудын үлдэгдэл турь, Шивэрт ламын чулуун баримал, Соёмбо агуйн Бурхны дүрс хөрөг, Шилийн Чойжоогийн хэвтээ дүрс, Дунгийн суурингийн удган ширээ, БНМАУ-ын баатар Х.Дамбын хөшөө, Дунд Баяны эхний бичигт ханан...,
- Хэрлэн сумын нутагт: Саригийн голын баруун этгээдийн бичигт хад, ЗХУ-ын нэр нь тодроогүй дайчдын дурсгалд зориулсан багана,
- Цэнхэрмандал сумын нутагт: Нугаар бригадын нутагт буй эртний байлдааны хориглолт /шивээ/-ын хэсэг, Бургастайн түрэг бичээс
- Жаргалтхаан сумын нутагт: Гичгэнэ бригадын Дуулга ууланд байгаа Хүннүгийн үеийн 137 ширхэг булш, мөн сумын төвийн зүүн хойно орших мэлхий чулуу,
- Мөрөн сумын нутагт: Салбар уулан дахь Киданы бичигт хад, Хэрлэнгийн хойд хөвөөнд орших зүүн баруун хэрэм,
- Баянмөнх сумын нутагт: Баянцогт, Хэрээ, Хөхөл уулын олон булш эдгээр нь олон янзын овог аймгийн булш бололтой. Сумын төвөөс баруун хойш Гүн бүрдийн зүүн эрэгт орших Түрэгийн үеийн толгойгүй, хоёр хүн чулуун хөшөө, сумын төвийн зүүн өмнө буй Түрэгийн үеийн хөшөө
- Дархан сумын нутагт: Хоёрдугаар бригадын нутаг Хар чулуутын булагт байдаг бичигт хад, Дархан уулын оройд байсан том дөшийг Х.Пэрлээ авчирч Улсын төв музейд өгсөн.
- Буянт сумын /өнөөгийн Галшар сум Б.Д/ нутагт: Эртний сүм хийдийн турь, эвдэрхий балгад, Арвин бригадын нутгийн бичигтэй босоо хөшөө чулуу

- Баян-Овоо сумын нутагт: Гүрэмийн нуурын урд эргийн чулуун зэвсгийн бууц, Талын хөндлөнд буй Зөвлөлтийн дайчдын дурсгалд зориулсан багана, Баянмөнхийн хоолойн бичигт хөшөө, сумын төвийн өмнөх толгойн арын эртний чулуун зэвсгийн бууц, Толгойтын бичигт хад,
- Батноров сумын төвд: 1959 оны байгалийн аюултай тэмцэж амь үрэгдсэн Цэнджав, Янжмаа нарын дурсгалын хөшөө,
- Биндэр сумын нутагт: Жаргалант нуурын дэргэдэх бичигт хад, рашаан хадны бичиг, Чулуун дуулгатын чулуун дээлга, Биндэр уулын өврийн хадны бичиг,
-Өндөрхаан хотын нутагт: Баруун өмнө байдаг Түрэгийн үеийн гэлэн хөшөө, Ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулан босгосон өндөрлөг, Бөх, морь, сур, саальчин, бугын баримлууд, Цэцэн ханы ордны дөрвөн байшин, Зөвлөлтын дайчдын дурсгалын хөшөө ..., гэсэн дурсгалуудыг оруулсан байна.

Хэнтий аймгийн АХД-ын Гүйцэтгэх Захиргааны дээрх тогтоолд орсон дурсгалуудын холбогдох он цаг, оршин буй газар нутаг, нэршил зэргийг буруу ташаа бичсэн цөөнгүй алдаа мадаг байдаг хэдий ч анх удаа өөрийн нутагт орших эртний түүх, соёлын дурсгалуудыг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн чухал шийдвэр болсныг дурдууштай.

1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргасны дараа Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор хуучин СнЗ-ийн 1971 оны 420 дугаар тогтоолыг шинэчлэн “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт” нэрээр баталжээ. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д Хэнтий аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалт:

- Биндэр сумын нутагт орших зураг, бичээстэй “Рашаан” хад буган чулуу
- Баян-Адрага сумын Дуурлиг нарс гэдэг газар орших хүннүгийн үеийн язгуууртны булш
- Дэлгэрхаан сумын Аваргын рашааны арын дэнжид орших Аваргын балгас
- Өндөрхаан сумын төвд орших хүн чулуун хөшөө ... гэсэн 4 дурсгалт газрыг

Аймгийн хамгаалалтад:

- Цэнхэрмандал сумын Бургастай гэдэг газар орших Түрэг бичээстэй хад
- Өндөрхаан сумын төвд орших Цэцэнхааны ордны цогцолбор
- Батширээт сумын нутагт орших Өглөгчийн хэрэм
- Мөрөн сумын нутагт орших Салбар уулын бичээс
- Өмнөдэлгэр сумын нутагт  орших Балдан Бэрээвэн хийд
- Өмнөдэлгэр сумын баруун Жаргалантын гэдэг газар орших сүг зурагтай хад
- Өмнөдэлгэр сумын дунд Жаргалантын адагт орших Буган чулуун хөшөө
- Жаргалтхаан сумын Дуулга гэдэг газар орших хүннүгийн үеийн булш
- Батширээт сумын Үзүүр цохионы зүүн талд орших сүг зурагтай хад
- Батширээт сумын Эгийн Живхээстэй гэдэг газар орших булшнууд
- Дадал сумын Гурваннуур гэдэг газар орших Чингис хааны хөшөө
- Дэлгэрхаан сумын Гүнбүрд гэдэг газар орших хүн чулуу ... зэрэг 12 дурсгалт газрыг оруулжээ.

1995-1998 онд УИХ-аас “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-д зарим өөрчлөлт оруулж шинээр аймаг, сум байгуулсан, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд хамгаалалтад оруулах шаардлагтай дурсгалууд шинээр илэрч олдсон зэрэг шалтгааны улмаас 1994 онд баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх шаардлага урган гарч ирсэн байна. Энэ шаардлагыг харгалзан Монгол улсын Засгийн газар 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Батширээт сумын нутагт орших зураг бичээстэй “Рашаан” хад, буган чулуун хөшөө
- Баян-Адрага сумын Дуурлиг нарс гэдэг газар орших хүннүгийн үеийн язгуууртны булш
- Баянхутаг сумын баруун Сэрвэн хаалга гэдэг газар буй бичигт хад
- Биндэр сумын Борбулаг гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- Дэлгэрхаан сумын Аваргын рашааны арын дэнжид орших Аваргын балгас
- Дэлгэрхаан сумын Их Хайлант, Шар хад, Ханангийн энгэрт байгаа олон төрлийн булшнууд, чулуун зэвсгийн үеийн бууц
- Өндөрхаан сумын төвийн дэргэд орших “Гэлэн” хэмээх хүн чулуу гэсэн 7 дурсгалт газрыг

Аймгийн хамгаалалтад:

- Батширээт сумын нутагт орших Өглөгчийн хэрэм

- Батширээт сумын Үзүүр цохио гэдэг газар орших сүг зурагтай хад
- Батширээт сумын Эгийн Живхээстэй гэдэг газар орших булшнууд
- Дэлгэрхаан сумын Гүн бүрд, Тооно ууланд орших хүн чулуу, хиргисүүр, булш зэрэг цогцолбор дурсгал
- Жаргалтхаан сумын Дуулга ууланд орших хүннүгийн үеийн булш
- Жаргалтхаан сумын Цэнхэрийн голын хэрэм
- Мөрөн сумын нутагт орших Салбар уулын бичээс
- Өмнөдэлгэр сумын нутагт орших Балдан Бэрээвэн хийд
- Өмнөдэлгэр сумын баруун Жаргалант гэдэг газар орших сүг зурагтай хад
- Өндөрхаан сумын төвд орших Цэцэнхааны ордны цогцолбор
- Цэнхэрмандал сумын Бургастай гэдэг газар орших Түрэг бичээстэй хад гэсэн 11 дурсгалт газрыг тус тус оруулжээ.

Дээрх 2 жагсаалтад Хэнтий аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас цөөнгүй дурсгал хамрагдаж орсон хэдий ч зарим нэг дурсгалын нэр, оршин буй газар орны нэрийг буруу бичиж оруулсан байна. Мөн зарим алдартай дурсгалын түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн үнэ цэнэ, ач холбогдлыг нь нарийвчлан тогтоож өгөөгүйн улмаас энэ жагсаалтад зайлшгүй орох ёстой дурсгалыг үлдээсэн, эсвэл улсын хамгаалалтад орох ёстой дурсгал аймгийн хамгаалалтад орсон цөөнгүй жишээ байдаг.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг сүүлийн 10 гаруй жилийн туршид шинээр илэрч олдсон олон арван дурсгалаар баяжуулан шинэчлэн баталсан юм. Хэнтий аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас уг жагсаалтын улсын хамгаалалтад:

- Батширээт сумын нутагт орших “Рашаан” хад, Үзүүр цохионы чулуун зэвсгийн бууц, хадны зураг, тамга, бичээс, булш, буган чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал
- Батширээт сумын Өглөгчийн хэрмийн туурь, булш
- Баян-Адрага сумын Дуурлиг нарс гэдэг газар орших Хүннүгийн язгууртны булш
- Баянхутаг сумын Сэрвэн хаалга гэдэг газар орших хадны бичээс
- Биндэр сумын Борбулаг гэдэг газар орших Хүннүгийн үеийн булшнууд
- Дэлгэрхаан сумын Аваргын рашааны арын дэнжид орших Аваргын балгас
- Дэлгэрхаан сумын нутагт орших Хэрлэнгийн Хөдөө арлын дурсгалууд
- Дэлгэрхаан сумын Их Хайлант, Шар хад, Ханангийн энгэр гэдэг газар орших олон үеийн булшнууд, чулуун зэвсгийн үеийн бууц
- Жаргалтхаан сумын Дуулга ууланд орших Хүннүгийн үеийн булшнууд
- Өмнөдэлгэр сумын Дунд Жаргалант гэдэг газар орших буган чулуун хөшөө, хиргисүүрүүд
- Өмнөдэлгэр сумын Балдан Бэрээвэн хийд, түүний орчмын хаданд сийлсэн бурхадын зураг
- Хэрлэн сумын төвд орших Цэцэн ханы ордны цогцолбор
- Хэрлэн сумын төвд орших “Гэлэн” гэдэг хүн чулуун хөшөө гэсэн 13 дурсгалт газрыг

Аймгийн хамгаалалтад:

- Батширээт сумын Эгийн Живхээстэйн амны хүн чулуун хөшөө
- Батширээт сумын Баянголын ам нутагт орших хүн чулуу
- Батноров сумын Тунсаг овооны хадны зураг
- Батноров сумын Дүнгэнэдэг гэдэг газар орших туурай тамга бүхий дурсгал
- Баянмөнх сумын Дулаан уулын олон үеийн булшнууд
- Баянхутаг сумын Соно уул, Баянцагааны хүн чулуун хөшөөнүүд
- Биндэр сумын Асгат ууланд орших чулуун зэвсгийн бууц, дөрвөлжин булшнууд
- Биндэр сумын Ононгийн Улаан эргийн булшнууд
- Дархан сумын Хоодойн булгийн дэрсний хүн чулуун хөшөө
- Дэлгэрхаан сумын Гүнбүрд. Тооно ууланд орших хүн чулуун хөшөө, хиргисүүр, булш бүхий цогцолбор дурсгал
- Дэлгэрхаан сумын Долоод, Бурхан толгойн булш,  хиргисүүрүүд
- Дэлгэрхаан сумын Хөшөөнө-Ухаа гэдэг газар орших хүн чулуу, тахилын чулуун хавтангууд
- Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан уулын Хүйтэн хошуу, Бухын хошууны булшнууд
- Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан уулын Хэрээ хошууны булш, хиргисүүрүүд
- Жаргалтхаан сумын Барууны-Ар гэдэг газар орших хүн чулуун хөшөө

- Жаргалтхаан сумын Цэнхэрийн голын хэрэм
- Мөрөн сумын нутагт орших Салбар уулын бичээс
- Мөрөн сумын Баруун, Зүүн хэрэм
- Норовлин сумын Чингэсийн хэрмэн зам
- Өмнөдэлгэр сумын Дээд Өлзийтийн дөрвөлжин булшнууд
- Өмнөдэлгэр сумын төвд орших буган чулуу хөшөө
- Өмнөдэлгэр сумын Жаргалант гэдэг газар орших хадны зураг
- Цэнхэрмандал сумын Бургастай гэдэг газар орших хадны түрэг бичээс гэсэн 23 дурсгалт газрыг тус тус оруулжээ. Сүүлийн жилүүдэд түүх, археологи, угсаатны зүйн судалгаа гадаадын өндөр хөгжилтэй орнуудын туслалцаа дэмжлэгтэйгээр тогтмолжиж байгаатай холбоотойгоор Хэнтий аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалуудыг шинээр илрүүлэх, судалж шинжих ажил өргөжин тэлсээр байна. Энэ ажлын үр дүнд тус аймгийн нутгаас үнэ цэнэ, ач холбогдол нь бүс нутгийн хэмжээнд үнэлэгдэхээр олон арван дурсгал шинээр олдож төрийн хамгаалалтад орох нь эргэлзээгүй юм.

Монгол улсын Засгийн газрын 1998 оны 51 дүгээр тогтоолоор батлагдан гарсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийн 2,22-д Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Балдан Бэрээвэн хийдийг консевацих хийж, бэхжүүлж хамгаалахаар, 3,16, 3,17-д мөн аймгийн Хэрлэн сумын нутагт орших хүн чулуун хөшөө, Батширээт сумын Рашаан хадны дурсгалыг аянга зайлуулагчтай болгохоор, 5.31, 5.32, 5.33-д Биндэр сумын Рашаан хадны дурсгал дахь тамга, дүрс, бичээсийн, Мөрөн сумын Салбар уулын бичээсийн, Цэнхэрмандал сумын Бургастайн түрэг бичээсийн хэв дардасыг авч хамгаалахаар, 7.24, 7.25-д Биндэр сумын Рашаан хадны дурсгалыг, Батширээт сумын Өглөгчийн хэрэмийг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулахаар тус тус оруулжээ. Дээр дурдсан ажлуудаас 3 газрын бичээс, тамга, тэмдгийн хэв дардасыг авах ажил бүрэн биелэгдэж бусад нь төсөв хөрөнгийн эх үүсвэр, цаг хугацаа, хүн хүчний нөөц бололцоог буруу тооцоолсноос болж хэрэгжээгүй байна.

Дээр дурдсан хөтөлбөрийг олон агуулгаар баяжуулан цаашид дэс дараатай үргэлжлүүлэхийн тулд Засгийн газар 2007 оны 303 дугаар тогтоолоор шинээр боловсруулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг батлан гаргасан юм. Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа түүх, соёл, шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой дурсгалуудаас нэн тэргүүнд авран хамгаалах шаардлагатай дурсгалуудыг сонгон оруулжээ. Хэнтий аймгаас 2007 оны энэ хөтөлбөрийн 7.1.4-т Хэрлэн сумын нутагт орших Сэцэн ханы ордонг сэргээн засварлахаар, 7.3.4-т Баянхутаг сумын нутагт орших Сэрвэн хаалганы бичээсийг цэвэрлэж бэхжүүлэн хэв дардас авахаар, 7.5.9-д Батширээт сумын нутагт орших Рашаан хадны тамга бичгийн дурсгалыг цэвэрлэж бэхжүүлэн аялал жуулчлалын маршрутад хамруулахаар тус тус орсон байна. Өнөөдрийн байдлаар дээрх ажлуудын дийлэнх хувь нь бүрэн хэрэгжээд байна.

## 6. Өлийн давааны энгэрийн дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн урагш 12 орчим км-т Өлийн давааны урд энгэрт, машин замын зүүн талд цувраа 3 дөрвөлжин булш бий.



Өлийн давааны энгэрийн дөрвөлжин булш (зүүнээс)



Өлийн давааны энгэрийн дөрвөлжин булш (баруун урдаас)

## 7. Тойн өвөлжөөний дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн урд зүгт 30-аад км, Шуусын голын зүүн бие. Тойн уулын урд энгэрт орших өвөлжөөний орчмоор 20 гаруй дөрвөлжин булш бий.



Тойн өвөлжөөний дөрвөлжин булш (урдаас)



Тойн өвөлжөөний дөрвөлжин булш (урдаас)

## 8. Эрхэт толгойн ар шилийн булш

Сумын төвөөс баруун хойш 20-иод км-т Онон голын хойд эрэг, Эрхэт толгойн ар шилээр уртрагийн дагуу цувран байрласан 10 орчим булш бий.



Эрхэт толгойн ар шилийн булш (урдаас)

# БАЯНМӨНХ СУМ

Баянмөнх сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 2,6 мян.км$^2$ газар нутагтай, 4 багтай, 1547 хүн амтай, 70784 толгой малтай байна. Сумын төв Улаан эрэг суурин нь аймгийн төвөөс зүүн хойш 100 км зайтай.







1. Агуйт уулын агуй
2. Алтан өлгийн хиргисүүр
3. Баянмөнхийн хийдийн туурь
4. Баянцагааны талын хүн чулуун хөшөө
5. Баянцогтын дөрвөлжин булш
6. Гүнбүрдийн хүн чулуун хөшөөд
7. Их Цагаан усны хөшөө чулууд
8. Холбоо уулын өврийн булш, хиргисүүр
9. Холбоо уулын хөшөө чулуу

### 1. Агуйт уулын агуй

Сумын төвөөс баруун урд зүгт 30-аад км-т, Агуйт гэх ханан хадтай уул бий. Энэ уулын ханан хадны хормойд чулуугаар өрж хаалга гаргасан жижиг агуй байдаг. Агуйд дээхэнэ үед лам нар сууж даяан хийдэг байжээ.



Агуйт уул (урдаас)



Агуйт уулын агуйн үүд (урдаас)

### 2. Алтан өлгийн хиргисүүр

Сумын төвөөс баруун урагш 30 гаруй км-т Алтан өлгий гэх уул бий. Энэ уулын энгэр бэлээр 3 хиргисүүр, цөөн хэдэн дөрвөлжин булшийн хамт оршино.



Алтан өлгийн хиргисүүр (урдаас)



Алтан өлгийн хиргисүүр (урдаас)

### 3. Баянмөнхийн хийдийн туурь

Сумын төвөөс баруун хойш 30-аад км, Хэрлэн голын хойд хөндийд Баянмөнхийн хийдийн туурь оршино. Уг туурийг зарим хүмүүс Бүрдийн дацангийн туурь ч гэх нь бий. Хийдийн туурин дээр цөөн хэдэн барилгын суурь чулуу үлджээ.



Баянмөнхийн хийдийн туурь (баруун урдаас)

### 4. Баянцагааны хүн чулуун хөшөө

Сумын төвөөс зүүн урагш 15 орчим км, Баянцагаан уулын баруун урд бэлд, Баянцагааны талын гар худгийн баруунтаа нэгэн хүн чулуун хөшөө сул хэвтэнэ.



Баянцагааны талын хүн чулуун хөшөө (урдаас)



Баянцагааны талын хүн чулуун хөшөө (баруун урдаас)



Баянцагааны талын хүн чулуун хөшөөний гар зураг



Гүнбүрдийн 1-р хүн чулуун хөшөө



Гүнбүрдийн 2-р хүн чулуун хөшөө

### 5. Баянцогтын дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн тийш 25 орчим км, Хэрлэн голын урд бие, Баянцогтын булан гэх газар 60 гаруй дөрвөлжин булш бий. Эдгээр булшны ойр орчмоор чулуун зэвсгийн үлдэгдэл цөөнгүй байх ажээ.



Баянцогтын дөрвөлжин булш (урдаас)

### 6. Гүнбүрдийн хүн чулуун хөшөөд

Сумын төвөөс баруун хойш 30-аад км, Хэрлэн Тооно уулын зүүнтээ, Гүнбүрд хэмээх жижиг нуурын зүүн эрэг дээр цагаан саарал боржин чулуугаар үйлдсэн хоёр хүн чулуун хөшөө бий.



Гүнбүрдийн 1-р хүн чулуун хөшөөний гар зураг



Гүнбүрдийн 2-р хүн чулуун хөшөөний гар зураг

### 7. Их Цагаан усны хөшөө чулууд

Сумын төвөөс зүүн урагш 35 орчим км, Их Цагаан усны хөндий гэх газар гадаргуу дээрээ ямар нэг тамга тэмдэггүй 3 босоо, 1 хэвтээ чулуу бий. Үүнийг нутгийнхан хөшөө чулуу гэдэг.



Их Цагаан усны хөшөө чулууд (урдаас)



Их Цагаан усны хөшөө чулууд (зүүн урдаас)

### 8. Холбоо уулын өврийн булш, хиргисүүр

Сумын төвөөс урагш 27 орчим км, Холбоо уулын салбар, Дулаан уулын энгэр бэлээр дөрвөлжин дугуй нийлсэн 20 гаруй булш, хэдэн хиргисүүр бий.



Холбоо уулын өврийн булш, хиргисүүр (баруун урдаас)



Холбоо уулын өврийн дөрвөлжин булш (зүүн урдаас)

### 9. Холбоо уулын хөшөө чулуу

Сумын төвөөс урагш 26 орчим км, Холбоо уулын өвөр, Дулаан уулын баруун урд хормойд гадаргуу дээрээ тамга тэмдэггүй, 6 тал бүхий хөшөө чулуу бий.



Холбоо уулын хөшөө чулуу (зүүн урдаас)



Холбоо уулын хөшөө чулуу (баруун урдаас)

# БАЯН-ОВОО СУМ

Баян-Овоо сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Мөнххан уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 3,4 мян.км$^2$ газар нутагтай, 4 багтай, 1694 хүн амтай, 89822 толгой малтай байна. Сумын төв Жавхлант суурин нь аймгийн төвөөс зүүн тийш 135 км зайтай.







1. Вангийн хийдийн туурь
2. Гүрэмийн нуурын чулуун зэвсгийн дурсгалт газар
3. Жаргалантын хийдийн туурь
4. Загийн амны бичигт хадны бичээс
5. Майхант уулын чулуун зэвсгийн дурсгалт газар
6. Торлогтын дөрвөлжин булш
7. Уртын хоолойн Улаан энгэрийн хөшөө чулуу
8. Ханзат хотын туурь
9. Хар Ямаатын булш
10. Хулстын хөшөө чулуу
11. Цагаан усны хоолойн хөшөө чулуу
12. Цонжийн тахилын байгууламж

### 1. Вангийн хийдийн туурь

Сумын төвөөс зүүн урагш 20-иод км, Хэрлэн голын хойд хөвөө, Улаан эрэг гэх газар Вангийн хийдийн туурь бий. Туурийн орчим том жижиг 10 гаруй барилгын ор мөр мэдэгдэнэ.



Вангийн хийдийн туурь (баруун урдаас)



Вангийн хийдийн туурь (баруун урдаас)

### 2. Гүрэмийн нуурын чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс зүүн зүгт 7 орчим км-т орших Гүрэмийн нуурын эрэг хөвөөгөөр неолитын үед холбогдох чулуун зэвсгийн үлдэгдэл цөөнгүй олддог.



Гүрэмийн нуур (зүүн урдаас)



Гүрэмийн нуурын чулуун зэвсгийн үлдэгдэл

### 3. Жаргалантын хийдийн туурь

Сумын төвийн баруун хойд талд байх эмх замбараагүй хөглөрөх хэсэг чулуутай газар хуучин Жаргалантын хийд байсан ажээ.



Жаргалантын хийдийн туурь (баруун урдаас)



Жаргалантын хийдийн туурь (баруун хойноос)

### 4. Загийн амны бичигт хадны бичээс

Сумын төвөөс урагш 30 гаруй км-т Загийн амны Бичигт хад хэмээх газар 4 мөр монгол, 2 мөр төвд бичиг бий.



Загийн амны бичигт хадны төвд бичээс (урдаас)



Загийн амны бичигт хадны монгол бичээс (урдаас)

### 5. Майхант уулын чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс урагш 5 орчим км, Хэрлэн голын урд хөвөө, Майхант уулын зүүн хойд талд түүхийн олон үед холбогдох дурсгал бүхий газар бий. Эндээс неолитын үеийн чулуун зэвсгийн үлдэгдэл, төрөл бүрийн хүрэл, төмөр эдлэлийн хэсэг, ваарны хагархайнууд олддог.



Майхант уулын чулуун зэвсгийн дурсгалт газар (зүүн хойноос)



Майхант уулын чулуун зэвсгийн дурсгалт газраас олдсон эд өлгийн зүйлс

### 6. Торлогтын дөрвөлжин булш

Сумын төвөөс урд зүгт 25 орчим км-т Уртын хоолойн Торлогт гэх намхан торлог ихтэй уул бий. Энэ уулын баруун суганд том хавтгай чулуугаар хашлага хийсэн сүрлэг 7 дөрвөлжин булш бий.



Торлогтын дөрвөлжин булш (зүүнээс)



Торлогтын дөрвөлжин булш (баруун урдаас)

### 7. Уртын хоолойн Улаан энгэрийн хөшөө чулуу

Сумын төвөөс урд зүгт 26 орчим км-т, Уртын хоолойн Торлогтын эсрэг талын Улаан энгэр гэх газар гадаргуу дээрээ тамга, тэмдэггүй боржин чулуун хөшөө бий.



Уртын хоолойн Улаан энгэрийн хөшөө чулуу (зүүн урдаас)



Уртын хоолойн Улаан энгэрийн хөшөө чулуу (баруун урдаас)

### 8. Ханзат хотын туурь

Сумын төвөөс зүүн зүгт 40-өөд км-т, Хэрлэн голын хойд хөвөөнөө Ханзат гэх эртний хотын туурь бий. Эндээс барилгын суурь чулуу, тоосго, дээврийн ваарны үлдэгдэл олддог байна.



Ханзат хотын туурь (баруун урдаас)



Ханзат хотын туурин дээрх эд өлгийн зүйлс

### 9. Хар Ямаатын булш

Сумын төвөөс зүүн урагш 20-иод км-т Хар Ямаатын салбар уулсын энгэр бэлээр дөрвөлжин дугуй нийлсэн нэлээд хэдэн булш бий. Эдгээр булшнаас ойрын үед хүмүүс ухаж сүйтгэсэн байна.



Хар Ямаатын булш (хойноос)



Хар Ямаатын булш (зүүн урдаас)

### 10. Хулстын хөшөө чулуу

Сумын төвөөс баруун урагш 10-аад км-т, тахилын байгууламжийн хашлага бололтой хэдэн чулуудын баруун урд талд зүүн урагш хазайсан боржин чулуун хөшөө бий.



Хулстын хөшөө чулуу (баруун урдаас)



Хулстын хөшөө чулуу (урдаас)

### 11. Цагаан усны хоолойн хөшөө чулуу

Сумын төвөөс баруун урагш 40-өөд км-т, Цагаан усны хоолой гэх газар нутгийнхны “Чингисийн морины уяа“ гэж нэрлэдэг саарал боржин хөшөө чулуу бий.



Цагаан усны хоолойн хөшөө чулуу (хойноос)



Цагаан усны хоолойн хөшөө чулуун дээрх ханз

### 12. Цонжийн тахилын байгууламж

Сумын төвөөс баруун урагш 10-аад км-т, Хэрлэн голын урд хөвөөнд орших нэгэн өндөр эргийг Цонж гэнэ. Энэ эргийн зах ирмэгээр уртрагийн дагуу байрлалтай 10-аад тахилын байгууламж бий.



Цонжийн тахилын байгууламж (зүүнээс)



Цонжийн тахилын байгууламж (урдаас)

Баянхутаг сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Өндөрхан уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 6,0 мян.км$^2$ газар нутагтай, 3 багтай, 2105 хүн амтай, 171014 толгой малтай байна.  Сумын төв Баян суурин нь аймгийн төвөөс зүүн урагш 22 км зайтай.




1. Баруун Хаалганы өврийн булш, хиргисүүр, тахилын байгууламж
2. Баян хүрээ уулын Улаан ханангийн хүннү булш, чулуун зэвсгийн дурсгалт газар
3. Далан харын хөшөө чулуу
4. Дашчимбий хийдийн туурь
5. Модонгийн чулуун зэвсгийн дурсгалт газар
6. Модонгийн эртний хот хэрмийн үлдэгдэл
7. Өгөөмөрийн булангийн хөшөө чулуу
8. Өгөөмөр уулын энгэрийн булш, хиргисүүр
9. Соно уулын урд ухаагийн хүн чулуун хөшөө
10. Сэрвэн Хаалганы бичээс
11. Урд Баяны цогцолбор дурсгал
12. Хулгар ухаагийн хүн чулуун хөшөө
13. Цагаан овооны Хөшөөтийн хөшөө чулуу

### 1. Баруун Хаалганы өврийн булш, хиргисүүр, тахилын байгууламж

Сумын төвөөс зүүн хойд 20-иод км-т Хэрлэн голын урд биед байх салбар ихтэй уулыг Баруун Хаалга гэнэ. Энэ уулын энгэр бэлээр 40 орчим булш, хиргисүүр оршино.



Баруун Хаалганы өврийн хиргисүүр (урдаас)



Баруун Хаалганы өврийн булш (баруунаас)

### 2. Баян хүрээ уулын Улаан ханангийн Хүннү булш, чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс зүүн тийш 30-аад км-т өргөрөгийн дагуу байрлалтай том хүрэн уул байдгийг Баян хүрээ уул гэнэ. Энэ уулын баруун хэсэгт орших хэрэм мэт ханан хясааг Улаан ханан гэдэг. Улаан ханангийн урбэлээр 40 гаруй хүннү булш, болон неолитын үед холбогдох чулуун зэвсгийн үлдэгдэл бий.



Баруун Хаалганы өврийн тахилын байгууламж (зүүн урдаас)



Баян хүрээ уулын Улаан ханангийн хүннү булш (урдаас)



Баян хүрээ уулын Улаан ханангийн чулуун зэвсгийн үлдэгдэл



Баян хүрээ уулын Улаан ханангийн хүннү булшнууд (зүүн хойноос)

### 3. Далан харын хөшөө чулуу

Сумын төвөөс зүүн урагш 17 орчим км-т, Далан хар уулын энгэрт гадаргуу дээрээ ямар нэг тамга, тэмдэггүй боржин чулуун хөшөө бий.


Далан харын хөшөө чулуу (урдаас)

### 4. Дашчимбий хийдийн туурь

Сумын төвөөс ялимгүй баруун урагш 25 орчим км-т Дашчимбий хийдийн туурь бий. Хийдийн туурийн орчимд 10-аад барилгын туурь үлдэгдэх харагдах ба түүн дээр элдэв барилгын хэрэглэгдэхүүн хөглөрөх ажээ.


Дашчимбий хийдийн туурь (баруун урдаас)


Дашчимбий хийдийн туурь (зүүн урдаас)

### 5. Модонгийн чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс хойд зүгт 15 орчим км-т Хэрлэн голын урд биед Модонгийн хөндий гэж уудам хөндий бий. Эндээс неолитын үед холбогдох чулуун зэвсгийн үлдэгдэл ихээр олддог.


Модонгийн чулуун зэвсгийн үлдэгдэл


Модонгийн чулуун зэвсгийн дурсгалт газар (зүүн урдаас)

### 6. Модонгийн эртний хот хэрмийн үлдэгдэл

Сумын төвөөс хойд зүгт 17 орчим км-т Хэрлэн голын урд хөвөө, Модонгийн хөндийн хойд хэсэгт эртний нэгэн шороон хэрэм бий. Хэрмийн ойролцоогоос Киданы үеийн бололтой ваарны хагархай их олддог.


Модонгийн эртний хот хэрмийн үлдэгдэл (зүүн хойноос)

**7. Өгөөмөрийн булангийн хөшөө чулуу**

Сумын төвөөс баруун хойш 30-аад км, Хэрлэн голын урд биед, Өгөөмөрийн үзүүр гэх газар гадаргуу дээрээ тамга тэмдэг, дүрсгүй боржин чулуун хөшөө бий.



Өгөөмөр уулын булш, хиргисүүр (баруун урдаас)



Өгөөмөрийн өврийн хөшөө чулуу (урдаас)

**8. Өгөөмөр уулын энгэрийн булш, хиргисүүр**

Сумын төвөөс баруун тийш 30-аад км-т Өгөөмөр гэх багавтар уул бий. Энэ уулын энгэр бэлээр булш, хиргисүүр, тахилын байгууламж нийлсэн 60-аад дурсгал бий.



Өгөөмөр уулын дөрвөлжин булш (баруун хойноос)

**9. Соно уулын урд ухаагийн хүн чулуун хөшөө**

Сумын төвөөс баруун урагш 45 орчим км-т Соно уулын урд ухаа дээрх чулуун овоолгын дунд баруун хойш хазайсан нэгэн хүн чулуун хөшөө бий. Уг хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар үйлджээ.



Соно уулын урд ухаагийн хүн чулуун хөшөө (зүүн урдаас)



Соно уулын урд ухаагийн хүн чулуун хөшөөний гар зураг

## 10. Сэрвэн Хаалганы бичээс

Сумын төвөөс зүүн хойд зүгт 20 гаруй км-т Хэрлэн голын урд хөндийд хадтай зэрэгцсэн шовх уул бий. Үүнийг Сэрвэн Хаалга гэнэ. Энэ уулын дунд хэрд хоорондоо 10-аад м зайтай хоёр том чулууны наран зүгт харсан хавтгай тал дээр хятад, зөрчид бичээсийг сийлжээ. Эдгээр бичигт Чингис хааны Татаруудтай хийсэн байлдааны тухай өгүүлдэг ажээ.



Сэрвэн Хаалга уул (зүүн урдаар)



Сэрвэн Хаалганы зөрчид бичээс



Сэрвэн Хаалганы хятад бичээс

## 11. Урд Баян уулын цогцолбор дурсгал

Сумын төвөөс зүүн хойд зүгт 30-аад км, Баян хүрээ уулын зүүн урд биед Урд Баян гэх багавтар уул бий. Энэ уулын хадтай оройн хэсгээр хадны сийлмэл зураг, төвд монгол бичээс, 10-аад булш бүхий цогцолбор дурсгал байдаг.



Урд Баян уулын хадны зураг (урдаас)



Урд Баян уулын төвд, монгол бичээс (урдаас)



Урд Баян уулын булш (урдаас)

### 12. Хулгар ухаагийн хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун урагш 60-аад км-т Үнэгт уулын баруун талд орших намхан ухааг Хулгар ухаа гэдэг. Энэ ухаагийн орой дээр овоолсон чулууны дунд боржин чулуугаар хийсэн хүн чулуун хөшөө бий.



Хулгар ухаагийн хүн чулуун хөшөө (баруун урдаас)



Хулгар ухаагийн хүн чулуун хөшөө (урдаас)



Хулгар ухаагийн хүн чулуун хөшөөний гар зураг

### 13. Цагаан овооны Хөшөөтийн хөшөө чулуу

Сумын төвөөс зүүн хойд зүгт 30-аад км-т Хэрлэн голын урд бие, Цагаан овооны Хөшөөт гэх газар хойшоо харсан гадаргуу дээрээ тамгатай боржин чулуун хөшөө бий.



Цагаан овооны Хөшөөтийн хөшөө чулуу (зүүн урдаас)



Цагаан овооны Хөшөөтийн хөшөө чулууны гар зураг



Цагаан овооны Хөшөөтийн хөшөө чулуун дээрх тамга

Биндэр сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Биндэръяа уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 5,4 мян.км$^2$ газар нутагтай, 5 багтай, 3824 хүн амтай, 123541 толгой малтай байна. Сумын төв Онон суурин нь аймгийн төвөөс хойш 184 км зайтай.







1. Амгалантын амны суврага
2. Бага Могойн амны хадны зураг
3. Борбулагийн амны булш
4. Доод Борбулагийн дөрвөлжин булш
5. Залаагийн дөрвөлжин булш, хөшөө чулуу
6. Сансарын Улаан эргийн булш, хиргисүүр
7. Сэрүүний хөндийн дөрвөлжин булш
8. Тахилтын зүүн үзүүрийн дөрвөлжин булш, чулуун зэвсгийн дурсгалт газар
9. Хадтай толгойн булш, чулуун зэвсгийн дурсгалт газар
10. Хөшөөн дэвийн хөшөө чулуу
11. Эрдэнэ өндөрийн булш

## 1. Амгалантын амны суврага

Сумын төвөөс зүүн хойд зүгт 70-аад км-т, Амгалантын аманд хуучны нэгэн суврага бий. Үүнийг нутгийнхан бурхан шатаадаг бааюу гэдэг. Эдүгээ сүврагын үлдэгдэл дээр шавар бурхадын хэсэг цөөнгүй байдаг.



Амгалантын амны сувраган дээрх шавар эдлэлийн хэсэг



Амгалантын амны суврага (зүүн урдаас)

## 2. Бага Могойн амны хадын зураг

Сумын төвөөс хойд зүгт 70 орчим км-т, Бага Могойт гэж модтой, хад асгатай уул бий. Энэ уулын шувтрагад баруун тийш харсан хадны ёроолоор улаан зосон зураг байдаг.



Бага Могойтын зосон зураг



Бага Могойтын зосон зурагтай хад (баруун урдаас)

## 3. Борбулагийн амны булш

Сумын төвөөс ялимгүй зүүн урагш 20 гаруй км-т Онон голын урд бие, Цармын талбай хэмээх уужим хөндийд, Борбулагийн амны адгаар олон үед холбогдох 120 гаруй булш бий.



Борбулагийн амны түрэг булш (урдаас)



Борбулагийн амны хүннү булш (урдаас)

#### 4. Доод Борбулагийн дөрвөлжин булш

Сумын төвийн зүүн урагш 4-5 орчим км, Онон голын зүүн эрэгт хойноос урагш сунан тогтсон нүцгэн уул байдгийг Доод Борбулаг гэдэг. Энэ уулын оройгоор дөрвөлжин дугуй нийлсэн 30 гаруй булш байдаг.



Доод Борбулагийн дөрвөлжин булш (зүүн урдаас)



Доод Борбулагийн дөрвөлжин булш (зүүн урдаас)

#### 5. Залаагийн амны дөрвөлжин булш, хиргисүүр хөшөө чулуу

Сумын төвөөс зүүн хойд зүгт 6 орчим км, Залаа хэмээх хадтай уулын энгэрт 2 булш, гадаргу дээрээ дүрслэлгүй нэг хөшөө чулуу бий.



Залаагийн амны дөрвөлжин булш хиргисүүр, (урдаас)



Залаагийн амны хиргисүүр, хөшөө чулуу (баруун урдаас)

#### 6. Сансарын улаан эргийн булш, хиргисүүр

Сумын төвөөс хойш 5 км, Онон голын зүүн хойд эрэг, Сансарын улаан эрэг хэмээх газар 1 хиргисүүр, 10-аад булш бий. Энэ булш, хиргисүүрийг нутгийнхан 1000 цэргийн булш гэж домоглон ярилцдаг байна.



Сансарын улаан эргийн булш (баруун урдаас)



Сансарын улаан эргийн булш (зүүнээс)

### 7. Сэрүүний хөндийн дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн хойш 80-аад км, Сэрүүний хөндийгөөр урсан Жаргалантын голын хойд энгэрээр 50 гаруй дөрвөлжин булш бий. Булшнуудын дунд урд талдаа онгин тамгатай жижиг хөшөө байдаг.



Сэрүүний хөндийн дөрвөлжин булш (баруун урдаас)



Сэрүүний хөндийн дөрвөлжин булш (зүүн хойноос)



Сэрүүний хөндийн дөрвөлжин булшны дунд орших онгин тамгатай хөшөө чулуу (урдаас)

### 8. Тахилтын зүүн үзүүрийн дөрвөлжин булш, чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс зүүн тийш 30-аад км, Онон голын хойд эрэг, Тахилт хэмээх хадтай уулын зүүн үзүүрт 30 орчим булш, неолитын үед холбогдох чулуун зэвсгийн дурсгалт газар оршино.



Тахилтын зүүн үзүүрийн чулуун зэвсгийн үлдэгдэл



Тахилтын зүүн үзүүрийн чулуун зэвсгийн үлдэгдэл



Тахилтын зүүн үзүүрийн булш (урдаас)


Хадтай толгойн дөрвөлжин булш (зүүнээс)

## 9. Хадтай толгойн булш, чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс урагш 30-аад км-т Хадтай толгой хэмээх хад асга ихтэй багавтар уулын энгэрээр дөрвөлжин дугуй нийлсэн 80 гаруй булш бий. Мөн неолитын үед холбогдох чулуун зэвсгийн үлдэгдэл их олддог.


Хадтай толгойн чулуун зэвсгийн үлдэгдэл


Хөшөөн дэвийн тахилын байгууламж (зүүнээс)

## 10. Хөшөөн дэвийн хөшөө чулуу

Сумын төвөөс баруун урагш 50-иад км, аймгийн төв явдаг замын хойд биед Хөшөөн дэв хэмээх газар дүрслэлгүй хөшөө чулуу бүхий тахилын байгууламж бий.

## 11. Эрдэнэ өндөрийн булш

Сумын төвөөс зүүн тийш 30-аад км, Эрдэнэ өндөр хэмээх багавтар уулын энгэрээр 30 гаруй дөрвөлжин булш, 10 гаруй дугуй булш бий.


Эрдэнэ өндөрийн булш (зүүнээс)


Эрдэнэ өндөрийн булш (урдаас)

# ГАЛШАР СУМ

Галшар сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Галшар уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 6,7 мян.км$^2$ газар нутагтай, 6 багтай, 2154 хүн амтай, 145160 толгой малтай байна. Сумын төв Буянт суурин нь аймгийн төвөөс урагш 134 км зайтай.




1. Бага Артын Чингисийн зам
2. Бичигтийн хадны зураг, чулуун зэвсгийн дурсгалт газар
3. Зараагийн энгэрийн дөрвөлжин булш, хиргисүүр
4. Зүүнбулагийн шандны хөшөө чулуу
5. Их Артын хиргисүүр
6. Сайн усны эхний хиргисүүр
7. Ухаа овоотын булш
8. Хужиртын хийдийн туурь
9. Цацын голын хөшөө чулууд



Бага Артын Чингисийн зам (зүүн хойноос)

**1. Бага Артын Чингисийн зам**

Сумын төвөөс зүүн хойш 30 гаруй км, Бага Арт гэх багавтар уулын дунд баруун эрэгш чиглэсэн чулуун далан бий. Энэхүү чулуун даланг нутгийнхан Чингисийн зам гэж нэрийддэг байна.



Бага Артын Чингисийн зам (зүүн хойноос)

**2. Бичигтын хадны зураг, чулуун зэвсгийн дургсалт газар**

Сумын төвөөс зүүн хойд зүгт 40 гаруй км, Бага Арт уулын хойд талд Бичигт хад хэмээх газар хэдэн сийлмэл зураг бий.



Бичигт хадны сийлмэл зураг



Бичигт хадны орчмын чулуун зэвсгийн үлдэгдэл

**3. Зараагийн энгэрийн дөрвөлжин булш, хиргисүүр**

Сумын төвөөс баруун тийш 15-17 орчим км, Дондойн Зараа уулын энгэрт дөрвөлжин булш, хиргисүүр, тахилын байгууламж нийлсэн 30 гаруй дурсгал бий.



Зараагийн энгэрийн дөрвөлжин булш (зүүн урдаас)



Зараагийн энгэрийн дөрвөлжин булш (урдаас)

**4. Зүүнбулагийн шандны хөшөө чулуу**

Сумын төвөөс хойд зүгт 20 гаруй км, Зүүнбулагийн шанд хэмээх газар урт гонзгой боржин чулууг засалгүй босгосон хөшөө чулуу бий. Хөшөөний гадаргуу дээр ямар нэг тамга, тэмдэг байхгүй юм.



Зүүнбулагийн шандны хөшөө чулуу (урдаас)



Их Артын хийдийн туурь (урдаас)

**5. Их Артын хийдийн туурь, булш**

Сумын төвөөс хойд зүгт 40 орчим км, Их Арт уулын энгэрт хуучны нэгэн хийдийн туурь, хэдэн булшны хамт зэрэгцэн оршино.



Их Артын булш (урдаас)

**6. Сайн усны эхний хиргисүүр**

Сумын төвөөс хойд зүгт 40-өөд км Их Артын хийдийн туурнаас урагш 4 орчим км, Сайн усны эх гэх газар дугуй хүрээтэй хоёр хиргисүүр бий.



Сайн усны эхний хиргисүүр (зүүн урдаас)

**7. Ухаа овоотын булш**

Сумын төвөөс баруун зүгт 30 гаруй км-т Ухаа овоо гэх намхан уулын урд энгэрт хүнну бололтой 10-аад булш бий.



Ухаа овоотын хүнну булш (зүүн урдаас)



Ухаа овоотын хүнну булш (зүүн урдаас)


Хужиртын хийдийн туурин дээр сэргээсэн дуган (зүүн урдаас)

## 8. Хужиртын хийдийн туурь

Хэнтий аймгийн төвөөс Галшар сумруу явдаг замын дэргэд /сумын төвөөс 20-иод км/ Хужиртын хийдийн туурь бий. Энэ туурин дээр одоо Ганданшадав Даржаалин хийдийг сэргээн босгож хурал номын үйл ажиллагаа явуулж байна.


Хужиртын хийдийн туурь (баруун урдаас)


Цацын голын хөшөө чулуу (баруун урдаас)

## 9. Цацын голын хөшөө чулууд

Сумын төвөөс баруун зүгт 30-аад км-т Цацын голын хөндийд хавтгай чулуун хашлага бүхий хэдэн божин чулуун хөшөө бий. Эдгээр хөшөө чулуудын ихэнх нь газарт сул хэвтэх бөгөөд гадаргуу дээр нь ямар нэг тамга тэмдгийн зүйл байхгүй ажээ.


Цацын голын хөшөө чулууд (зүүн урдаас)

# ДАДАЛ СУМ

Дадал сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Биндэръяа уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 4,7 мян.км$^2$ газар нутагтай, 4 багтай, 2660 хүн амтай, 27294 толгой малтай байна. Сумын төв Баян-Овоо суурин нь аймгийн зүүн хойш 270 км зайтай.




1. Агцын хийдийн туурь
2. Амарлингуй уулын дөрвөлжин булш
3. Бага Яргайтын дөрвөлжин булш
4. Баянцагаан уулын зүүн үзүүрийн дөрвөлжин булш
5. Баянцагаан уулын өврийн булш
6. Дэгэний арын дөрвөлжин булш
7. Дэлүүн болдогийн овоо, дурсгалын гэрэлт хөшөө
8. Өлийн давааны хүннү булш
9. Угалзар голын дөрвөлжин булш
10. Хажуу бөөрийн хүннү булш
11. Хирийн хоолойн Бор хоолойн адгийн дөрвөлжин булш
12. Цэээний арын өндөрийн Хөхөчү бөөгийн агуй

## 1. Агцын хийдийн туурь

Сумын төвөөс зүүн хойд зүгт 50-иад км-т Агцын хийдийн туурь бий. Эдүгээ хийдийн туурин дээр хоёр барилгын туурь байх бөгөөд дээгүүр нь хэдэн чулуу хөглөрч харагдана.



Агцын хийдийн туурь (зүүн урдаас)



Агцын хийдийн туурь (зүүнээс)

## 2. Амарлингуй уулын дөрвөлжин булш

Сумын төвөөс урагш 10-аад км-т Онон голын баруун хойд талд, Баянцагаан уулын зүүнтээ Амарлингуй гэх уул бий. Энэ уулын өвөр бэлээр 100 гаруй дөрвөлжин булш буй.



Амарлингуй уулын дөрвөлжин булш (баруун урдаас)



Амарлингуй уулын дөрвөлжин булш (зүүн урдаас)

## 2. Бага Яргайтын дөрвөлжин булш

Сумын төвөөс баруун хойд зүгт 18 орчим км-т Түнхлэг горхины баруун хойд биед орших Бага Яргайт гэх газар 10-аад дөрвөлжин булш бий.



Бага Яргайтын дөрвөлжин булш (урдаас)



Бага Яргайтын дөрвөлжин булш (урдаас)

### 4. Баянцагаан уулын зүүн үзүүрийн дөрвөлжин булш

Сумын төвөөс урагш 10-аад км, Онон голын баруун хойд бие, Амарлингүй уулын баруун талд орших Баянцагаан уулын зүүн үзүүрт уртрагийн дагуу цуварч байрласан хэдэн дөрвөлжин булш бий.



Баянцагаан уулын зүүн үзүүрийн дөрвөлжин булш (баруунаас)



Баянцагаан уулын зүүн үзүүрийн дөрвөлжин булш (урдаас)

### 5. Баянцагаан уулын өврийн дөрвөлжин булш

Сумын төвөөс урагш 10-аад км, Онон голын баруун хойд бие, Амарлингүй уулын баруун талд орших Баянцагаан уулын энгэр бэлээр цөөнгүй дөрвөлжин булш бий.



Баянцагаан уулын өврийн дөрвөлжин булш (баруун урдаас)



Баянцагаан уулын өврийн дөрвөлжин булш (урдаас)

### 6. Дэгэний арын дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн зүгт 50 гаруй км, Онон голын хойд хөвөө, Дэгэн хэмээх уулын хойд биед орших нэгэн намхан ухаагийн нуруун дээр уртрагийн дагуу байрласан 4 дөрвөлжин булш бий.



Дэгэний арын дөрвөлжин булш (зүүнээс)



Дэгэний арын дөрвөлжин булш (зүүн урдаас)



Дэлүүн болдогийн овоо, дурсгалын гэрэлт хөшөө (баруун урдаас)

### 7. Дэлүүн болдогийн овоо, дурсгалын гэрэлт хөшөө

Сумын төвөөс зүүн тийш 5-6 орчим км, Балжийн голын урд хөвөөнд орших Дэлүүн болдог хэмээх газрыг Чингис хааны төрсөн газар овоо, гэрэлт хөшөө босгожээ.

### 8. Өлийн давааны хүннү булш

Сумын төвөөс баруун тийш 1-2 км-т Өлийн давааны оройн модон дунд хэдэн хүннү булш бий. Зарим булшны голд мод ургасан байна.



Өлийн давааны хүннү булш (баруун урдаас)



Өлийн давааны хүннү булш (зүүн урдаас)

### 9. Угалзар голын дөрвөлжин булш

Сумын төвөөс урагш 10-аад км, Амарлингуй, Баянцагаан уулын урд үзүүрт Онон голын цутгалан Угалзар голын хойд эрэг дээр 10-аад дөрвөлжин булш бий.



Угалзар голын дөрвөлжин булш (зүүнээс)



Угалзар голын дөрвөлжин булш (урдаас зүүнээс)

### 10. Хажуу бөөрийн хүннү булш

Сумын төвөөн зүүн хойд хэсэг, Баян-Овоогийн өндөр хэмээх толгойн Хажуу бөөр гэх газар хүннүгийн үеийн нэлээд булш бий.



Хажуу бөөрийн хүннү булш (зүүн урдаас)



Хажуу бөөрийн хүннү булш (баруун урдаас)

### 11. Хирийн голын Бор хоолойн адгийн дөрвөлжин булш

Сумын төвөөс зүүн хойд зүгт 75 орчим км-т Хирийн голын Бор хоолойн адаг гэх газар 40-өөд дөрвөлжин булш бий. Эндхийн 1 булшны хашлага чулуун дээр бугын зураг сийлсэн байна.



Хирийн голын Бор хоолойн адгийн дөрвөлжин булш (зүүн урдаас)



Хирийн голын Бор хоолойн адгийн дөрвөлжин булшны хашлага дээрх бугын сийлмэл зураг (зүүн урдаас)

### 12. Цээний арын өндөрийн Хөхөчү бөөгийн агуй

Сумын төвөөс зүүн урд зүгт 28 орчим км, Онон голын хойд бие, Цээний арын өндөр хэмээх хадтай шовх уул бий. Энэ уулын дунд хэрд байх шовх хадан дунд багавтар хадны хонгил байдаг. Үүнийг нутгийнхан Хөхөчү бөөгийн агуй хэмээн нэрлэдэг. Хөхөчү бөөгийн агуйруу өгсөн замд цөөнгүй булш бий.



Цээний арын өндөрийн Хөхөчү бөөгийн агуй (зүүн урдаас)

# ДАРХАН СУМ

Дархан сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 4,5 мян.км$^2$ газар нутагтай, 5 багтай, 11218 хүн амтай, 129298 толгой малтай байна. Сумын төв Дархан суурин нь аймгийн баруун урагш 15 км зайтай.




1. Ахай бэйсийн дуган
2. Гачитын дацангийн туурь
3. Дархан уулын булш, хиргисүүр
4. Дээд Хар өндөрийн дөрвөлжин булш, хиргисүүр
5. Ногоон уулын хадны зураг, булш
6. Талын хөшөө чулуу
7. Хараатын хийдийн туурь
8. Хар Чулуутын хөшөө чулуу
9. Ходойн хүн чулуун хөшөө
10. Хойд Зараагийн энгэрийн дөрвөлжин булш, хиргисүүр
11. Шавартайн чулуун зэвсгийн дурсгалт газар
12. Шивээ уулын энгэрийн булш, хиргисүүр

**1. Ахай бэйсийн дуган**

Сумын төвийн урд хэсэгт хуучны нэгэн модон дуган бий. Энэ дуган нь Ахай бэйсийн хүрээнээс ганц босоо үлдсэн барилгын дурсгал ажээ.



Ахай бэйсийн дуган (зүүн урдаас)

**2. Гачитын дацангийн туурь**

Сумын төвөөс зүүн тийш 14 орчим км-т Мандал уулын өвөрт Гачитын дацангийн туурь бий. Энд эмх замбараагүй болсон барилгын суурь чулууд цөөн хэдэн мод, төмрийн үлдэгдэл үлдэжээ.



Гачитын дацангийн туурь (баруун урдаас)

Гачитын дацангийн туурь (баруунаас)

**3. Дархан уулын булш, хиргисүүр**

Сумын төвөөс баруун хойд зүгт 7-8 км, Дархан уулын баруун урд бэл, Цагаан толгой хэмээх газар хоорондоо нэлээд зайтай 10 орчим дөрвөлжин булш, 1 хиргисүүр бий.



Дархан уулын хиргисүүр (урдаас)



Дархан уулын дөрвөлжин булш (зүүн урдаас)

### 4. Дээд Хар өндөрийн дөрвөлжин булш, хиргисүүр

Сумын төвөөс хойд зүгт 30-аад км, Хэрлэн голын урд эрэг Дээд Хар өндөр хэмээх уулын хойд бэлд дугуй хүрээтэй 1 хиргисүүр, 30-аад дөрвөлжин булш нэг дор бүлэглэн оршино.



Дээд Хар өндөрийн дөрвөлжин булш (баруун урдаас)



Дээд Хар өндөрийн булш, хиргисүүр (зүүн урдаас)

### 5. Ногоон уулын хадны зураг, булш

Сумын төвөөс урд зүгт 50 гаруй км, Бор-Өндөр тосгоноос баруун зүгт 10 гаруй км-т Ногоон гэх нэгэн жижигэвтэр уул бий. Энэ уулын энгэр бэлээр 6-7 булш, оройн хэсгийн хаданд эртний сийлмэл зургийн дурсгал бий.



Ногоон уулын хадны зураг (урдаас)



Ногоон уулын хадны зураг (зүүн урдаас)



Ногоон уулын булш (урдаас)

### 6. Талын хөшөө чулуу

Сумын төвөөс урагш 60-аад км, Бор-Өндөр тосгоноос зүүн урд зүгт 10-аад км-т Хүйхийн уулын ур хөндий, Талын хөндий хэмээх газар нэгэн боржин чулуун хөшөө бий. Хөшөөний оройд жижиг онгин тамга сийлсэн байдаг.



Талын хөшөө чулуу (зүүн урдаас)

### 7. Хараатын хийдийн туурь

Сумын төвөөс баруун урагш 40-өөд км, Хараат хэмээх газар өнөөгийн 2-р багийн төвийн орчимд хуучны хийдийн туурь бий. Энэ хийдийн туурийг Хараатын гэх бөгөөд олон гудамж байсныг гэрчлэх байшингийн эгнэсэн суурь үлдэгдэлүүд их ажээ.



Хараатын хийдийн туурь (баруунаас)



Хараатын хийдийн туурь (зүүн урдаас)

### 8. Хар чулуутын хөшөө чулуу

Сумын төвөөс баруун урагш 50-иад км, Хар чулуут гэх газар нэгэн боржин чулуун хөшөө бий. Хөшөөний гадаргуу дээр ямар нэг тамга мэдэг, дүрс, бичгийн дурсгал байхгүй.



Хар чулуутын хөшөө чулуу (зүүн урдаас)

### 9. Ходойн хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун тийш 20 орчим км, Ходойн Бор өндөрийн зүүн урд талд, булгийн зүүнтээх дэрсэн дунд цагаан саарал өнгийн боржин чулуугаар урласан нэгэн хүн чулуун хөшөө сул хэвтэнэ. Хөшөөний ойр орчмоор эртний гэх дурсгал байхгүй юм.



Ходойн хүн чулуун хөшөө
(зүүн урдаас)



Ходойн хүн чулуун хөшөө



Ходойн хүн чулуун хөшөөний гар зураг

## 10. Хойд Зараагийн энгэрийн дөрвөлжин булш, хиргисүүр

Сумын төвөөс урагш 40-өөд км, Дэлгэрэхийн голын зүүнтээ орших Хойд Зараа уулын энгэрээр цөөнгүй дөрвөлжин булш, хиргисүүр бий.



Хойд Зараагийн энгэрийн дөрвөлжин булш (баруун урдаас)



Хойд Зараагийн энгэрийн хиргисүүр (зүүн хойноос)

## 11. Шавартайн чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс хойд зүгт 10-аад км, Дархан уулын зүүн хойд бие Шавартайн булгийн эхэнд шинэ чулуун зэвсгийн үеийн суурин буй. Эндээс улаан хүрэн, шар, ногоон хас чулуугараа үйлдсэн чулуун зэвсгийн үлдэгдэл цөөнгүй ажээ.



Шавартайн чулуун зэвсгийн суурин (зүүнээс)







Шавартайн чулуун зэвсгийн үлдэгдэл

## 12. Шивээ уулын энгэрийн булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун урагш 10 гаруй км, Шивээ уулын энгэрт хэдэн булш, хиргисүүр бий.



Шивээ уулын энгэрийн хиргисүүр (баруун урдаас)



Шивээ уулын энгэрийн хиргисүүр (урдаас)

# ДЭЛГЭРХААН СУМ

Дэлгэрхаан сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 4,0 мян.км$^2$ газар нутагтай, 4 багтай, 2473 хүн амтай, 127952 толгой малтай байна. Сумын төв Цагаандэвсэг суурин нь аймгийн баруун тийш 125 км зайтай.







1. Аварга тосонгийн дэргэдэх чулуун дурсгалууд
2. Аваргын балгас
3. Бургалтайн амны адгийн булш, хиргисүүр, чулуун зэвсгийн дурсгалт газар
4. Долоодын өврийн булш, хиргисүүр
5. Сүжийн талын хүн чулуун хөшөө
6. Ханангийн энгэрийн дөрвөлжин булш
7. Ханангийн энгэрийн хөшөө чулуу
8. Хэрлэн Тооно уулын өврийн булш хиргисүүр
9. Чингисийн гүүн зэлний гадас хэмээх доод хөшөө чулуу
10. Чингисийн гүүн зэлний гадас хэмээх дунд хөшөө чулуу
11. Чингисийн гүүн зэлний гадас хэмээх дээд хөшөө чулуу
12. Шар хадны бичээс

### 1. Аварга тосонгийн дэргэдэх чулуун дурсгалууд

Сумын төвөөс баруунтаа орших Аварга тосонгийн рашаан сувилалын хашааны гадна талд тахилын онгоны хавтан чулуу 3, тээрмийн чулуу 2 ширхэг байна. Эдгээр чулуун дурсгалуудыг Гүнбүрд гэх газраас авчирсан ажээ.



Аварга тосонгийн дэргэдэх тахилын онгоны хавтан чулуу (урдаас)



Аварга тосонгийн дэргэдэх чулуун дурсгалууд (баруун урдаас)

### 2. Аваргын балгас

Сумын төвөөс баруун урагш 7-8 км, Аваргын голын баруун хөвөөнөө эртний нэгэн хотын туурь буй. Үүнийг судлчид Чингис хааны Аураг орд хэмээн тогтоожээ.



Аваргын балгас (баруун хойноос)

### 3. Бургалтайн амны адгийн булш, хиргисүүр, чулуун зэвсгийн дурсгалт газар

Сумын төвөөс зүүн урагш 50 гаруй км, Хөвсгөл сумаас Замын-Үүд ордог зам дагуу орших Хуцын гашууны энгэрт 20-иод дугуй булш бий.



Бургалтайн амны адгийн чулуун зэвсгийн үлдэгдэл



Бургалтайн амны хиргисүүр (баруунаас)



Бургалтайн амны булш (зүүн урдаас)

### 4. Долоодын өврийн булш, хиргисүүр

Сумын төвийн баруун тийш 30-аад км-т Хэрлэн голын зүүн биед орших Долоод уулын энгэр бэлээр булш, хиргисүүр нийлсэн 70 гаруй дурсгал бий.



Долоодын өврийн булш (баруун урдаас)



Долоодын өврийн булш, хиргисүүр (урдаас)

### 5. Сүжийн талын хүн чулуун хөшөө

Сумын төвийн баруунтаа орших Аварга тосонгийн рашаан сувилалын хашаан дотор нэгэн хүн чулуун хөшөө сул хэвтэнэ. Энэхүү хөшөө анх Сүжийн тал хэмээх газар байсан ажээ.



Сүжийн талын хүн чулуун хөшөөний гар зураг



Сүжийн талын хүн чулуун хөшөө (зүүн урдаас)

### 6. Ханангийн энгэрийн дөрвөлжин булш

Сумын төвөөс баруун тийш 15 орчим км, Ханангийн энгэр хэмээх газар олон тооны дөрвөлжин булш бий. Мөн энэ орчмоос хайрган чулуугаар үйлдсэн чулуун зэвсгийн үлдэгдэл олддог байна.



Ханангийн энгэрийн дөрвөлжин булш (урдаас)



Ханангийн энгэрийн дөрвөлжин булш (баруун урдаас)

**7. Ханангийн энгэрийн хөшөө чулуу**

Сумын төвөөс баруун тийш 15 орчим км, Ханангийн энгэрийн дөрвөлжин булшнуудын зүүн урд гадаргуу дээрээ тамга, тэмдэгтэй хөшөө чулуу сул хэвтэж буй.



Ханангийн энгэрийн хөшөө чулуу



Ханангийн энгэрийн хөшөө чулууны гар зураг

**8. Хэрлэн Тооно уулын булш, хиргисүүр**

Сумын төвөөс зүүн урагш 20-иод км-т Хэрлэн голын хойд хөвөөнөө Хэрлэн Тооно уул оршино. Энэ уулын энгэр, бэл, хормойгоор олон тооны булш, хиргисүүр, тахилын онгон зэрэг эртний дурсгалууд бий.



Хэрлэн Тооно уулын өврийн дөрвөлжин булш (урдаас)



Хэрлэн Тооно уулын өврийн хиргисүүр (баруун урдаас)



Хэрлэн Тооно уулын өврийн тахилын байгууламж (зүүн хойноос)

### 9-11. “Чингисийн гүүн зэлний гадас” хэмээх хөшөө чулууд

Сумын төвөөс баруун урагш 12-15 км-т Хэрлэн голын хойд хөвөө, Сужийн тал хэмээх газар “Чингисийн гүүн зэлний гадас” хэмээн нэрлэгддэг 3 хөшөө чулуу бий. Эдгээр хөшөөд хоорондоо 2-5 км зайтай оршино.



Чингисийн гүүн зэлний гадас” хэмээх доод хөшөө чулуу (зүүн урдаас)



“Чингисийн гүүн зэлний гадас” хэмээх дунд хөшөө чулуу (зүүнээс)



“Чингисийн гүүн зэлний гадас” хэмээх дээд хөшөө чулуу (баруун урдаас)

### 12. Шар хадны бичээс

Сумын төвөөс хойд зүгт 20 гаруй км-т Шар хадны амны адагт орших ханан хаданд улаан зосоор зурсан тамга тэмдэг мөн улаан зос хар бэхээр ашиглан төвд үсгээр бичсэн 5-6 мөр төвд маанийн үсэг бий.



Шар хадны тамга тэмдэг, бичгийн дурсгал (урдаас)

Жаргалтхаан сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Баянхан уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 2,8 мян.км$^2$ газар нутагтай, 5 багтай, 1964 хүн амтай, 131843 толгой малтай байна. Сумын төв Жаргалтхаан суурин нь аймгийн баруун тийш 100 км зайтай.







1. Баруун Жаргалантын арын хүн чулуун хөшөө
2. Бүрдэн дэнжийн дөрвөлжин булш, хөшөө чулуу
3. Гичгэний хөндийн булш, тахилын байгууламж
4. Дуулга уулын хүннү булш
5. Жаргалтхаан уулын булш
6. Талын дөрвөлжин хэмээх эртний хотын туурь
7. Тахилтын хийдийн туурь
8. Хар Модон толгойн эхний бичээс
9. Холбоо толгой, Баруун Шавартайн эхний дөрвөлжин булш
10. Хорхойтын хөндийн дөрвөлжин булш
11. Эсрүүгийн дөрвөлжин булш, хиргисүүр

### 1. Баруун Жаргалантын арын хүн чулуун хөшөө

Сумын төвөөс баруун хойш 7-8 км, Цагаан нуурын зүүн бие, Баруун Жаргалантын ар хэмээх газар нэгэн хонхорын зүүн урд талын овгор дээр 1 хүн чулуун хөшөө, тахилын онгоны хэдэн хавтангуудын хамт оршино.



Баруун Жаргалантын арын хүн чулуун хөшөө (урдаас)



Баруун Жаргалантын арын хүн чулуун хөшөөний гар зураг

### 2. Бүрдэн дэнжийн дөрвөлжин булш, хөшөө чулуу

Сумын төвөөс ялимгүй зүүн урагш 30-аад км, Цэнхэрийн голын баруун хөндий Бүрдэн дэнж хэмээх газар нэг дөрвөлжин булш, зүүн тийш хазайсан нэг хөшөө чулууны хамт бий. Хөшөөний гадаргуу дээр тамга тэмдгийн зүйл байхгүй юм.



Бүрдэн дэнжийн хөшөө чулуу (баруун урдаас)



Бүрдэн дэнжийн дөрвөлжин булш (баруун урдаас)

### 3. Гичгэний хөндийн дөрвөлжин булш, хиргисүүр, тахилын байгууламж

Сумын төвөөс зүүн урд зүгт 25 орчим км, хуучин багийн төвийн урд талын Гичгэний хөндийд дөрвөлжин булш, хиргисүүр, тахилын байгууламж нийлсэн 10-аад дурсгал бий.



Гичгэний хөндийн дөрвөлжин булш (баруун урдаас)



Гичгэний хөндийн дөрвөлжин булш (баруун урдаас)


Дуулга уулын хүнну булш (урдаас)

## 4. Дуулга уулын хүнну булш

Сумын төвөөс зүүн урагш 30-аа км-т Дуулга уулын баруун урд энгэрээр 15 орчим хүнну булш бий. Эдгээр булшнаас өмнө нь Монгол-Зөвлөлтийн археологчид малтан судалж түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой олон арван эд өлгийн зүйлийг олжээ.


Дуулга уулын хүнну булш (баруун урдаас)

## 5. Жаргалтхаан уулын булш

Сумын төвөөс баруун тийш 2-3 км, Жаргалтхаан уулын баруун урд энгэрээр дугуй дараастай хэдэн булш бий.


Жаргалтхаан уулын булш (баруун урдаас)


Жаргалтхаан уулын булш (урдаас)


Талын дөрвөлжингийн шороон далан (зүүн хойноос)

## 6. Талын дөрвөлжин хэмээх эртний хотын туурь

Сумын төвөөс баруун урагш 20-иод км, Цэнхэрийн голын зүүн хөндийд Талын дөрвөлжин буюу Чингисийн далан гэж нэрлэгддэг шороон хэрэм бүхий эртний хотын туурь бий.

### 7. Тахилтын хийдийн туурь

Сумын төвөөс хойд зүгт 30 гаруй км, Тахилт гэх уулын зүүн урд бэлд хуучны хийдийн туурь бий. Энэ хийдийн туурин дээр нутгийнхан суврага бүтээн залжээ.



Тахилтын хийдийн туурин дээр бүтээсэн суврага (зүүнээс)



Тахилтын хийдийн туурь (зүүн урдаас)

### 8. Хар модон толгойн эхний бичээс

Сумын төвөөс хойд зүгт 50-иад км, хуучин багийн төвөөс баруун хойш 10 гаруй км, Хар Модон төгөл гэх нэгэн өнчин ханан хад бий. Энэ хадны урагш харсан тэгш гадаргуу дээр бурхны шашны холбогдолтой улаан зосоор бичсэн төвд бичиг, тамга зургийн дурсгал бий.



Хар Модон толгойн бичигт хад (баруун урдаас)



Хар Модон толгойн бичигт хадан дээрх бичээс



Хар Модон толгойн бичигт хад (урдаас)



Хар Модон толгойн бичигт хадан дээрх хас тэмдэг

### 9. Холбоо толгой, Баруун Шавартайн эхний дөрвөлжин булш

Сумын төвөөс хойд зүгт 20-иод км, Холбоо толгой, Баруун Шавартайн эх хэмээх газар хэдэн дөрвөлжин булш нэг дор оршино.



Холбоо толгой, Баруун Шавартайн эхний дөрвөлжин булш (урдаас)



Холбоо толгой, Баруун Шавартайн эхний дөрвөлжин булш (урдаас)

### 10. Хорхойтын хөндийн тахилын байгууламж

Сумын төвөөс баруун хойш 40-өөд км, Хорхойтын хөндий хэмээх газар 2 хэсэг нийт 10-аад тахилын байгууламж бий. Эдгээрээс хэдийг археологчид малтан судалсан гэнэ.



Хорхойтын хөндийн тахилын байгууламж (зүүн хойноос)



Хорхойтын хөндийн тахилын байгууламж (баруун хойноос)

### 11. Эсрүүгийн дөрвөлжин булш, хиргисүүр

Сумын төвөөс баруун хойд зүгт 5-6 км, Жаргалтхаан уулын хойд бэл, Эсрүү хэмээх газар дугуй хүрээтэй нэг хиргисүүр, хоёр дөрвөлжин булшны хамт бий.



Эсрүүгийн дөрвөлжин булш (баруун урдаас)



Эсрүүгийн дөрвөлжин булш, хиргисүүр (баруунаас)

# МӨРӨН СУМ

Мөрөн сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Өндөрхан уулын хошууны нутгаас салган Хэнтий аймгийн харьяанд байгуулжээ. Тус сум 2009 оны сүүлийн байдлаар 2,2 мян.км$^2$ газар нутагтай, 5 багтай, 1904 хүн амтай, 108299 толгой малтай байна. Сумын төв Мөрөн суурин нь аймгийн баруун тийш 27 км зайтай.




1. Баруун хэрэм
2. Бумбатын хүн чулуун хөшөө, хөшөө чулуу
3. Бүсийн хийдийн туурь
4. Дэлгэр уулын энгэрийн булш
5. Зүүн хэрэм
6. Могойт хошууны тахилын байгууламж
7. Мөрөн сумын орчмын булш, хиргисүүр
8. Нарийн дэлийн хиргисүүр, тамгатай хөшөө
9. Салбар уулын бичээс
10. Уртын амны булш, хиргисүүр, тахилын байгууламж
11. Хатан уулын энгэрийн булш
12. Худагтын амны Буурал уулын булш, тахилын байгууламж
13. Чингисийн зэлний чулууд хэмээх хөшөө чулуу
14. Чингисийн тулгын чулуу хэмээх хөшөө чулууд
15. Эрдэнэ уулын бичээс


Баруун хэрмийн зүүн хойд булан (хойноос)

### 1. Баруун хэрэм

Сумын төвөөс зүүн урагш 27 орчим км-т Хэрлэн голын хойд хөвөөнөө /Дойтын талд/ хоорондоо 2 орчим км-ийн зайтай эртний хоёр шороон хэрэм бий. Түүний баруун талынхыг "Баруун хэрэм" гэдэг.

### 2. Бумбатын хүн чулуун хөшөө, хөшөө чулуу

Сумын төвөөс зүүн урагш 25 орчим км-т, Хэрмийн баруун үзүүр, Бумбат гэх газар зэрэгцсэн хоёр хөшөө чулуу бий. Эдгээр хөшөөний баруун талынх нь хүний нүүрний дүрс бүхий хөшөө юм.


Бумбатын хүн чулуун хөшөө (урдаас)


Бумбатын хүн чулуун хөшөөний гар зураг


Бумбатын хөшөө чулууд (баруун урдаас)

### 3. Бүсийн хийдийн туурь

Сумын төвөөс баруун урагш 40-өөд км-т, Хэрлэн голын хойд бие, Бүсийн уулын баруун хөндийд хуучны нэгэн хийдийн туурь бий. Үүнийг нуутгийнхан "Бүсийн хийдийн туурь" гэдэг.


Бүсийн хийдийн туурь (баруунаас)


Бүсийн хийдийн туурин дээр шинээр бүтээсэн суврага

**4. Дэлгэр уулын энгэрийн булш, тахилын байгууламж**

